



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 3

- Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай Монгол Улсын хууль
- Орон сууц хувьчлах тухай Монгол Улсын хууль
- Дундын өмчлөлийн орон сууцны тухай Монгол Улсын хууль
- Төрийн бус байгууллагын тухай Монгол Улсын хууль
- Хоршооны тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Газрын тухай хуульд өөрчлөлт сруулах тухай Монгол Улсын хууль



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Хэвлэл

№

1997 оны 3-р сар

№3 /58/

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай	223
2.	Нөхөрлөл, компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	230
3.	Хоршооны тухай хуульд нэмэлт оруулах тухай	231
4.	Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	231
5.	Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны хуулийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	232
6.	Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай	232
7.	Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	233
8.	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	233
9.	Хэлэлцээрт нэгдэн орох тухай	234
10.	Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	234
11.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	236
12.	Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	237
13.	Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	238
14.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн үйл, заалт хүчингүй болсонд тооцож тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай	239
15.	Тайр дууу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлдөлт, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	240
16.	Хуудгийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцож тухай	240
17.	Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	241
18.	Орон сууц хувиулах тухай	241
19.	Дундын өмчлөлийн орон сууцны тухай	253
20.	Төрийн бус байгууллагын тухай	262
21.	Төрийн бус байгууллагын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	270

22.	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	271
23.	Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	273
24.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	275

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

25.	Хуульчдын төслийг буцаах тухай №2	276
26.	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №3	276
27.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай №4	277
28.	Хүн амын нийгэмийн хамгааллын талаар авах зарим арга хэмжээний тухай №5	277
29.	Зарим эрчин сайдын яамт татан буулгах, шинээр байгуулах тухай №6	279
30.	Түр хороо байгуулах тухай №7	279
31.	Монголбанкнд худалдан авах алтны болон Монголбанкнаас худалдах алт, мөнгөний хэмжээ тогтоох тухай №8	280
32.	Алт олборлолтын талаар авах зарим арга хэмжээний тухай №9	281
33.	Үндсэн хуулийн нэнийн 09 тоот дүгнэлтийн тухай №11	281
34.	Үндсэн хуулийн нэнийн 10 тоот дүгнэлтийн тухай №12	282
35.	Орон сууц хувьчлах, Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулиудыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай №13	283
36.	Зарим гишүүдийг Байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөх, шинээр батлах тухай №14	284
37.	Журам батлах, зарим зардлын хэмжээ тогтоох тухай №15	285
38.	Хаарын эхлэжт чуулганаар хэлэлцэх асуудлын тухай №16	285
39.	Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №17	290
40.	Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №19	291

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛОГЧИЙН ЗАРЛИГ

41.	Гомбосүрэнгийн Дамдинсүрэнд дэслэгч генерал цол олгох тухай №12	292
42.	Балтаны Эрдэнэбатад хошууч генерал цол олгох тухай №13	292
43.	ХБНГУ-ын иргэн В.М.Прохийг "Найрамдал" медалиар шагнах тухай №14	292
44.	Цэрэндлашийн Полмонг эрчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай №15	293
45.	Булгаагийн Алтангэрхнийг эрчин сайдаар төмөрлөх тухай №16	293
46.	Япон улсын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай №17	294
47.	О.Отгонсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай №18	294
48.	Ч. Авдайд Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай №19	295
49.	Д. Ганчимэгт Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай №20	295
50.	Зарим багш, ажилтныг одон, медалиар шагнах тухай №21	296
51.	Галдад харилцааны байгууллагын зарим ажилтныг одон, медалиар шагнах тухай №22	304
52.	Загарын Эрэндоод дипломат цол олгох тухай №23	305
53.	Зарим багш нарыг шагнах тухай №25	306

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН
ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлох, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай
хууль тогтоомж, түүний үйлчлэх хүрээ

1. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль тогтоомж нь Гндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад газар, газраас алтамагц зориулалт, эдийн засгийн агуулга алдах барилга байгууламж, тарьц суулгац, олон наст ургамал зэрэг болит болон хийсвэр ргаар хэмжиж болохуйц, тодорхой хил хязгартай эд хөрөнгийг Иргэний хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн улсын бүртгэлд бүртгэнэ.

4. Гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа Монгол Улсын иргэн, уулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлж болно.

3 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших,
ашиглах эрх үүсэх

1. Өмчлөгч хуульд заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгөө улсын бүртгэлд бүртгүүлснээр түүний өмчлөх эрх баталгаажина.

2. Үл хөдлөх эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад илжүүлэх гэрээ нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр олж тухайн үл хөдлөх эд хөрөнгийг гэрээний үндсэн дээр өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүснэ.

4 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн зарчим

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл нь хуулиар хориглосноос бусад нөхцөлд нээлттэй байна.

5 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага

1. Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх үйл ажиллагааг Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар /шаашинд "бүртгэлийн байгууллага" гэх/ хариуцна.

2. Бүртгэлийн байгууллагын эрх зүйн байдлыг энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор тодорхойлно.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийг гагцхүү энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүртгэлийн байгууллага хариуцна.

6 дугаар зүйл. Бүртгэлийн байгууллагын чиг үүрэг

Бүртгэлийн байгууллага дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

1/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлгийг хянан үзэж зохих шийдвэр гаргах;

2/үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэж улсын бүртгэлийн гэрчилгээ олгох;

3/үл хөдлөх эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхтэй холбогдсон болон барьцааны гэрээний бүртгэл хөтлөх;

4/үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдсон шаардлагатай мэдээлэл авахааг эрх бүхий этгээдэд зохих журмын дагуу гаргаж өгөх;

5/үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой гэрээний талаархи мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах;

6/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой бөригт бичгийн архивыг эрхлэн хөтлөх;

7/үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой газрын кадастрын зураглал түүний хэмжээ /масштаб/ болон шаардлагатай бусад үзүүлэлтүүдийг бүртгэлд хавсарган хадгалах;

8/хуульд заасан бусад чиг үүрэг.

7 дугаар зүйл. Бүртгэлийн байгууллагын зохион байгуулалт

1. Бүртгэлийн байгууллага нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэх үйл ажиллагааг орон нутагт эрхлэн явуулах нэгжтэй байна.

2. Бүртгэлийн байгууллагын дүрэм, улсын бүртгэгчийн ажилла журмыг Засгийн газар батална.

3. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийг улсын бүртгэгч хөтөлнө. Улсын бүртгэгч нь туслах бүртгэгчтэй байна.

4. Бүртгэлийн байгууллага нь кадастрын хэмжилт, үнэлгээн хяналт тавих үүрэг бүхий албатай байж болно.

5. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дэвтэр, маяг гэрчилгээний загварыг Хууль зүйн сайд батална.

8 дугаар зүйл. Бүртгэлийн хураамж, үйлчилгээний хөлс

1. Энэ хуульд заасан журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгийг бүртгүүлэхэд тэмдэгтийн хураамж төлнө.

2. Төрөөс хуульд заасан журмын дагуу зохих хураамж төлж шилжүүлэн авсан үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхэд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэмдэгтийн сураамжаас чөлөөтнө.

3. Тухайн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогссон эрхийг шилжүүлэх тэрээг бүртгэх, бүртгэлийн хуулбар хийх зэрэгт үйлчилгээний хөлс төлнө.

4. Үйлчилгээний хөлс, түүнийг дахиран зарцуулах журмыг Засгийн газар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ****9 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлэг гаргах**

1. Иргэн, хуулийн этгээд, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлгийг /илалшид "мэдүүлэг" гэх/ тухайн үл хөдлөх эд хөрөнгө байгаа газар орших бүртгэлийн байгууллагад гаргана.

2. Дундаа хамтран өмчилж байгаа үл хөдлөх эд хөрөнгийг бүртгүүлэхэд нэг мэдүүлэг гаргана. Энэ тохиолдолд өмчлөгч тус бүрийн зөвшөөрлийг бичгээр авсан байна.

3. Үл хөдлөх эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчилж байгаа өмчлөгч ус бүр өөрт ногдох хэсгээ бүртгүүлэхээр бие даан мэдүүлэг гаргана.

4. Нэг зориулалттай, нэгдмэл байдалтай ашиглагдах цогцолбор үл хөдлөх эд хөрөнгийг бүртгүүлэхэд нэг мэдүүлэг гаргана.

5. Мэдүүлэгт энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлүүдийг тусгах бөгөөд дараахь бичиг баримтыг хавсаргана:

1/тухайн үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг нотлох бичиг баримт;

2/тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, үнэлгээг тогтоосон эрх үхний байгууллагын бичиг баримт.

6. Мэдүүлэгт хавсаргах бичиг баримтыг нотариатаар батлан эргүүлсэн байна.

7. Мэдүүлэг гаргагч тухайн үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэхээс өмнө гаргасан мэдүүлгээ буцаан авах эрхтэй. Үүнхүү мэдүүлгээ буцаан авах нь мэдүүлгийг хүлээн авах журамтай дил байна.

8. Мэдүүлэг гаргагч нь тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаггүй бол тус улсад байнга оршин суугч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан дээрх эрхээ хэрэгжүүлж болох бөгөөд эн тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүрэн эрх нь нотариатад батлан гэрчлэгдсэн байна.

10 дугаар зүйл. Мэдүүлэг хүлээн авахаас татгалзах

1. Бүртгэлийн байгууллага нь мэдүүлгийн бүрдэл дутуу, эсхү мэдүүлэг гаргах үед тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч бую эзэмшигчийн талаар маргаантай байвал уг мэдүүлгийг хүлээ авахаас татгалзаж болно.

2. Ийнхүү татгалзсан үндэслэлийг мэдүүлэг гаргагчид албан ёсоо мэдэгдэж холбогдох материалын хамт буцаан хургүүлнэ.

11 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх журам

1. Бүртгэлийн байгууллага мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойт тухайн үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэсэн эсэхийг магадлан 3^р хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэх асуудлыг шийдвэрлэнэ.

2. Улсын бүртгэгч мэдүүлгийг хянаж, энэ хуулийн 9 дүгээр зүйл заасан шаардлагыг хангасан гэж үзвэл түүнийг улсын бүртгэл бүртгэх шийдвэр гаргах бөгөөд мэдүүлэг хүлээн авсан өдрөөр тухай үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэнэ.

Энэхүү шийдвэрийг үндэслэн туслах бүртгэгч зохих журмы дагуу үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тэмдэглэл хийж, улсын бүртгэгчийн хамт улсын бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурна.

3. Бүртгэлийн байгууллага нь бүртгэлийг буруу хийсэн бс залруулга хийж, түүнийг хүчингүй болгох үүрэг хүлээнэ.

12 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэл

1. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3, 4 дахь хэсэгт зааснаг бусад үл хөдлөх эд хөрөнгө тус бүрийг үл хөдлөх эд хөрөнгий улсын бүртгэлд /шашид "улсын бүртгэл" гэх/ тусад нь бүртг бөгөөд уг бүртгэлд дор дурдсан зүйлийг тусгана:

1/үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хэмжээ, зориулалт;

2/үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч иргэний овог, нэр, орши суугаа хаяг, иргэний паспортын болон регистрийн дугаар, гарь үсэг;

3/өмчлөгч нь хуулийн этгээд бсл түүний оноосон нэр, орши байгаа газар, улсын бүртгэлийн регистрийн дугаар, хуулий этгээдийг төлөөлөн үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эр бүхий этгээдийн овог нэр, оршин суугаа хаяг, иргэний паспорты болон регистрийн дугаар, гарын үсэг;

4/үл хөдлөх эд хөрөнгийг бүртгүүлэх болсон үндэслэл;

5/үл хөдлөх эд хөрөнгийг бусдын өмчлэл, эзэмшил, ашиглалт шилжүүлсэн, барьцаалсан тухай тэмдэглэл;

6/мэдүүлэг гаргасан огноо;

7/улсын бүртгэлийг хаах тухай тэмдэглэл, үндэслэл;

8/дээр дурдсан холбогдох бичиг баримтуудыг батлан гэрчилсэн этариатчийн овог нэр, регистрийн дугаар.

2.Хуулийн этгээд нь өөрийн үл хөдлөх эд хөрөнгө болон түүнийг /сдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэх гэрээг итгэмжлэсэн талөөлөгчөөр бүртгүүлдэхэд тухайн итгэмжлэл нь уг ийгууллагын эрх баригчид, нягтлан бодогч буюу түүний үүрэг /шээтгэгчийн гарын үсэг, тамга /тэмдэг/-тай байж нотариатаар тлан гэрчлэгдсэн байна.

13 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ

1.Үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэж, тухайн этгээд /түүний хууль ёсны өмчлөгч мөн болохыг баталгаажуулсан үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг /шаашид "бүртгэлийн гэрчилгээ" гэх/ өмчлөгчид олгоно.

2.Улсын бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн тэмдэглэлийг үндэслэн сын бүртгэгч бүртгэлийн гэрчилгээ олгоно. Гэрчилгээ олгох /рмыг Хууль зүйн сайд тогтооно.

3.Төрийн байгууллагаас олгосон гэрчилгээтэй үл хөдлөх эд рөнгийг улсын бүртгэлд бүртгэхдээ уг гэрчилгээнд бүртгэсэн тухай мдэглэл хийх замаар хууль ёсны өмчлөгч мөн болохыг талгаажуулна.

14 дүгээр зүйл. Улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах

1.Улсын бүртгэлд дор дурдсан үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт уулна:

1/үл хөдлөх эд хөрөнгө гэрээ, хэлцлийн үндсэн дээр бусдын члөл, эзэмшил, ашиглалтад шилжих;

2/эрх бүхий байгууллагын шийдвэрээр өмчлөгч, эзэмшигч рчлөгдөх;

3/үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ нь өөрчлөгдөх.

2.Улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө ийнхүү мэлт, өөрчлөлт хийсний улмаас эрх ашиг нь шууд хөндөгдөж лох иргэд, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын өшөөрлийг заавал авсан байна.

Иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар батлан рлүүдсэн байна.

3.Үл хөдлөх эд хөрөнгө өөр өмчлөгчид шилжсэн бол улсын ртгэлд энэ тухай тэмдэглэл хийж, улсын бүртгэлийн гэрчилгээг нэ өмчлөгчид олгоно.

4.Улсын бүртгэлд хийх нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлийн /тэрт тэмдэглэнэ

15 дугаар зүйл. Бүртгэлийн байгууллага тусгай тэмдэглэл хийх

Бүртгэлийн байгууллага дараахь тохиолдолд тусгай тэмдэглэлийг улсын бүртгэлд хийнэ:

1/хуулийн этгээд дамлуурсан тухай шүүхийн шийдвэр гарсан;

2/үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай шүүхийн шийдвэр гарсан;

3/өмчлөгчийг иргэний эрх зүйн эрхийн чадамжгүй, сураггүй алга болсонд тооцсон, нас барсан гэж зарласан тухай шүүхийн шийдвэр гарсан.

16 дугаар зүйл. Урьдчилсан тэмдэглэл хийх

1. Худалдан авагч болон өв залгамжлагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тэдний гаргасан хүсэлтийг үндэслэн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийнэ.

2. Худалдан авагч хүлээсэн үүртээ биелүүлээгүй нөхцөлд дээрх тэмдэглэлийг үндэслэн тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч бүртгэлийн байгууллагад хандаж урьдчилсан тэмдэглэлийг хүчингүй болгуулах эрхтэй.

3. Өмчлөгч урьдчилсан тэмдэглэл хүчинтэй байх хугацаанд тухайн үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулахдаа урьдчилсан тэмдэглэл хийлгэсэн этгээдийн нотарилтаар батлан гэрчлэгдсэн зөвшөөрлийн бичгээр авсан байна.

17 дугаар зүйл. Бүртгэлийг хаях.

Бүртгэлийн байгууллага нь өмчлөгчийн өргөдөл, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн улсын бүртгэлийг дор дурдсан тохиолдолд хаяж бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгоно:

1/өмчлөлийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгө устсан;

2/гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгө устсан;

3/эд хөрөнгө өмчлөх эрх дуусгавар болсон.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ БУСДЫН ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХӨЛБӨГДСӨН БОЛОН БАРЬЦААНЫ ГЭРЭЭНИЙ БҮРТГЭЛ

18 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдсон гэрээний бүртгэл

1. Өмчлөгч нь үл хөдлөх эд хөрөнгийг бусдын эзэмшил, ашиглалтад тодорхой хугацаатай буюу хугацаагүй шилжүүлэх гэрээг энэ хуульд заасны дагуу бүртгүүлнэ.

2. Үл хөдлөх эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхтэй холбогдсон гэрээг /шалшид "гэрээ" гэх/ энэ хуульд заасан журмын дагуу бүртгэснээр тухайн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн эрхийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдэнэ.

3. Гэрээг Иргэний хуульд заасан нөхцөл, журмын дагуу байгуулна.

4. Гэрээний бүртгэл нь дор дурдсан агуулгатай байна:

1/гэрээний төрөл, агуулга;

2/гэрээний талууд, тэдгээрийн эдэлбэл зохих өнцгой эрх;

3/гэрээний зүйл, түүний тодорхойлолт, үзүүлэлт;

4/гэрээний хугацаа;

5/гэрээгээр тохиролцсон үнэ;

6/гэрээ дуусгавар болох үндэслэл.

19 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний бүртгэл

1. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг энэ хуульд заасан журмын дагуу бүртгэнэ.

2. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний бүртгэлд дараахь зүйлийг тусгана:

1/барьцаалагч, барьцалуулагч, үүрэг хүлээгчийн нэр, хаяг, иргэний паспортын болон регистрын дугаар;

2/барьцааны зүйл, түүний тодорхойлолт;

3/барьцаагаар хангагдах үүргийн агуулга, хугацаа, үнэ.

3. Үл хөдлөх эд хөрөнгийг дахин барьцаалахаар хэд хэдэн гэрээ байгуулсан бол гэрээ тус бүрийг энэ зүйлд заасны дагуу бүртгэнэ. Барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөөс үүрэг гүйцэтгэгчийн нэхэмжлийн шаардлагыг хангахдаа барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн дарааллыг баримтална.

20 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд тэмдэглэл хийх

1. Гэрээг бүртгэсэн тухай улсын бүртгэлд тэмдэглэнэ.

2. Гэрээний талуудын эрх, үүрэг өөрчлөгдөх, гэрээ дуусгавар болох, гэрээний зохигчид өөрчлөгдөх үед улсын бүртгэлд нэмэлт тэмдэглэл хийнэ.

3. Гэрээ дуусгавар болоход уг гэрээтэй холбогдох тэмдэглэлийг хаана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

21 дүгээр зүйл. Албадан дуудлага худалдаа

Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг шүүхийн шийдвэрийн дагуу бүртгэлийн байгууллага зохион байгуулж, түүнийг

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд заасан журмын дагуу Шүүхийн шийдвэр биелүүлэх алба эрхлэн явуулна.

22 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэлээс нуун дарагдаулсан, түүний тоо хэмжээг нь бууруулсан, энэ хуульд заасан журмыг зөрчиж бүртгүүлсэн бол улсын бүртгэгч иргэнийг 5000-30000 төгрөг, албан тушаалтныг 15000-60000 төгрөг, хуулийн этгээдийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

2/энэ хуульд заасан журмыг зөрчсөн бүртгэх байгууллагын бүртгэгчийг шүүгч 30000-60000 хүртэл төгрөгөөр торгох.

2. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөнөөс учирсан хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн талүүлнэ.

3. Өмчлөгч үл хөдлөх эд хөрөнгөө энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жилийн дотор бүртгүүлээгүй бол дараагийн 5 жилд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хураамжийн хэмжээг 10 дахин нэмэгдүүлнэ.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

**НӨХӨРЛӨЛ, КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "баталгаа" гэсний дараа

"болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ." гэж, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "буцаан олгох нөхцөл" гэсний дараа "болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар" гэж, 89 дүгээр зүйлд "3.Үл хөдлөх эд хөрөнгөөр оруулах хөрөнгө нь улсын бүртгэлд бүртгэгдсэн байна." гэсэн 3 дахь хэсгийг тус тус нэмсүгэй!

2 дугаар зүйл. Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "а"-г дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"а/үл хөдлөх эд хөрөнгө улсын бүртгэлийн дугаар тус бүрээр".

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалтын "бүртгэх журам" гэсний дараа "болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар" гэж, 9 дүгээр зүйлд "6.Хоршооны үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлнэ." гэсэн 6 дахь хэсэг тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурасан агуулгатай 5 дахь заалтыг нэмсүгэй:

"5/үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн мэдээллийг ерөнхий дүнгээр."

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

**МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, БАНКНЫ
ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг "Зээлийн барьцаанд бариулах эд хөрөнгийн тодорхойлолт, үнэлгээ, хэрэв үл хөдлөх эд хөрөнгө бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг шалтгасан баримт, зээлийн батлан даалт, батлан даагчийн бүртгэл, судалгаа" гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Зээлийн барьцаанд бариулах үл хөдлөх эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна" гэсэн өгүүлбэрийг нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 231 дүгээр зүйлийн 3 дахь хэсгээс "Орон сууцнаас бусад . . ." гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Газар зохион байгуулалт нь Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрыг үр ашигтай, эхистой ашиглах, хамгаалах, газрыг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлэх, газрын эдийн засгийн чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн."

2/ 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Газрын нэгдмэл сангийн данс бүртгэлд газрын нэгдмэл санг газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид хуваарилсан байдал, тэдгээрийн газрын хэмжээ, энэ нь үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн холбогдох бүртгэлтэй таарч буй эсэх, газрын үнэлгээ, төлбөр, төлөв байдал, чанар, газрыг хамгаалах талаар гэсэн арга хэмжээ зэрэг үзүүлэлтийг зөсөг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр тусгана."

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг "Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд буй газраас үл салах түүх, соёлын дурсгалт зүйл, бусад үл

хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭРТ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1925 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Гаага хотноо батлагдсан “Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай” Гаагийн хэлэлцээр, 1967 оны 7 дугаар сарын 14-ний өдөр Стокгольм хотноо батлагдсан тус хэлэлцээрийн нэмэлт хэсэг “Стокгольмын нэмэлт акт”-д нэгдэн орсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг, 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Хувиараа хөдөлмөр эрхлэгч малчин,хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах нөхцөл, журмыг хуулиар тогтоож болно.”

2/15 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Ажлын байрны нөхцлийн ажиллагчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагын хүрээнд шийдвэрлэх боломжгүй, түүрчлэн

хөдөлмөрийн халуун, газрын доорх нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн "... мөнгөн хөрөнгийн" гэсний дараа "бие даасан" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, мөн зүйлийн 3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байдлаас нь хамааралтайгаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр ялгавартай төлөх ажил олгогчийн жагсаалтыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална."

2/20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт:

"1/ажил олгогч шимтгэл ногдох хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлогод ногдох шимтгэлийг нөхөн төлүүлдэг, мөн орлоготой тэнцэх хэмжээний алданги ногдуулна;

2/дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлдэг, шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувийн алданги ногдуулна;"

3/20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгоогүй саатуулсан бол сарын тэтгэвэр, тэтгэмжийн дүнгээс саатуулсан хоног тутамд тэтгэвэр авагчийн үйлчилүүлдэг банкны тухайн үеийн хугацаатай хадгаламжийн хүүгээр болсон алдангийг тэтгэвэр олголтыг саатуулсан нь тогтоогдсон банк, санхүү, нийгмийн даатгалын байгууллага нөхөн төлөх бөгөөд буруутай албан тушаалтанд 25000-50000 тогрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

4/27 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"Үндэсний зөвлөлийн дарга, бүрэлдэхүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлах бөгөөд Зөвлөлийн орлогч даргыг гурван тал зөвшилцөж аль нэг талын талөөлөгчөөс 2 жилийн хугацаагаар томилно."

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн "10-ны" гэснийг "15-ны", "20-ны" гэснийг "25-ны", мөн хэсгийн 2-ын "5-ны" гэснийг "10-ны", "20-ны"

гэснийг "25-ны", 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-ын "1,0 ба 2,0" гэснийг "1,0, 2,0 ба 3,0" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "... нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын даргатай зөвшилцөж тухайн шатны Засаг дарга томилно." гэснийг "... тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын дарга томилно" гэж өөрчилсүгэй.

6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Харин зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд нэг төрлийн сангийн хөрөнгөөс өөр төрлийн санд 6 хүртэл сарын хугацаагаар түр шилжүүлэн ашиглаж болно." гэснийг хассугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд дор дурасан агуулгатай 4¹ дүгээр зүйл нэмсүгэй:

"4¹ дүгээр зүйл. Даатгуулагчийн тэтгэвэр авах эрх хэрэгжинэ

Тэтгэвэр авах эрх үүсэх үед болон үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албангаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... чадвараа" гэснийг дараа "50-иас доошгүй хувиар" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хагас" гэснийг "50-иас доошгүй хувьнаар" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3. Газрын дор болон хөдөлмөрийн халуун нөхцөлд ажилласан даатгуулагч дор дурдсан боллыг хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1/нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол;

2/нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн халуун нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол."

5 дугаар зүйл. Энэ хуулийн 1,2,3 дугаар зүйлийг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс, 4 дүгээр зүйлийг 1997 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дор дурасанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Нийгмийн халамжийн тэтгэврийг тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшингийн 60 хувиар бодож олгоно."

2/6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Хүүхэд асарсны тэтгэмжийг тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшингийн 50 хувиар бодож сэр бүр олгоно."

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг "1/бие даан амьдрах чадваргүй, асран хамгаалж тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангүй, нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй," гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын "амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой" гэснийг "нэн ядуу амьдралтай" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС
ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ
ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, этгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг баталсантай олбогдуулан дор дурасан иргэдийн тэтгэврийг зогсоосугай.

1/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1,2,3 дахь хэсэгт заасан тэтгэвэр авах нөхцөл, болзлыг хангаагүй;

2/срдин өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доош уявтар агдаж, тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа;

3/тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, өдөлмөрийн гэрээгээр ажиллагч.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн дагуу тэтгэвэр нь огцрогдох иргэдийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, этгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан тэтгэвэр авах нөхцөл, болзлыг 1997 оны 6 дугаар сарын 1-ний өдөр үргэл хэвээр хэрэглэж байхаар тогтоосугай.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэвэр болон хүүхэд сарсны тэтгэмжийг Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, этгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр шинэчлэн огтоосугай.

4 дүгээр зүйл. 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу 5 жилийн хөдөлмөрийн аас, түүнтэй адилтгах орлогын дундажаар бодож шинэчлэн огтоосугай.

5 дугаар зүйл. Үнэ, тариф, амьжиргааны өртгийн өөрчлөлт, тэтгэвэр бодох цалин, хөдөлмөрийн хөлсний хоорондын зохистой ярицааг Засгийн газраас тогтоож мөрдүүлсүгэй.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАХИР ДУТУУ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛТ,
ТҮҮНД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын /талбай, шахилгаан, дулааны/ гэснийг "/талбай, халаалт, сар бүрийн 150 киловатт шахилгаан, цэвэр, бохир усны/" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Дараахь хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

1/Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйл;

2/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаас бусад ургамлыг элбэг ургамалд тооцно";

2/ 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Ургамлыг өлчин, хөнөөлт мэргэг амьтан, хөнөөлт шавьр нас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /эрхшил "төрийн захиргааны төв байгууллага" гэх/-ийн зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь төрийн өмчийн орон сууцыг иргэдэд хувьчлах явцад төрийн эрх бүхий байгууллага иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж

Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Дундын өмчлөлийн орон сууцны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/"нийтийн зориулалттай орон сууцны байшин" гэж бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь дөрөв ба түүнээс дээш сууцны зориулалттай барилгыг;

2/"орон сууц хувьчлах" гэж төрийн өмчийн нийтийн зориулалттай орон сууцны байшингийн сууц /өрөө/-ыг түүнийг хууль ёсоор эзэмшиж байгаа сууц эзэмшигчдийн өмчлөлд шилжүүлэхийг;

3/"сууц" гэж нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь нэг гэр бүл аж төрөхөд зориулагдсан нэг буюу хэд хэдэн өрөө бүхий цогцолборыг;

4/"орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгө" гэж нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахиагаан болон явган шат, шатны хөнгил, сууц хоорондын талбай, түүний тагт, дээвэр, тоног төхөөрөмж, орцны хаалга, дөвжөө, цонх, хөг зайлуулах хоолой, халаалт, халуун, хүйтэн усны удирдах зангилааны энхны хаалт хүртэл, цахилгааны оролтын самбар хүртэл, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэлх, шалны $\pm 0,00$ тэмдэгтээс дээшхи бохир усны шугам сүлжээг;

5/"сууц эзэмшигч" гэж нийтийн зориулалттай орон сууцны байшингийн сууц /нэг буюу нэгээс дээш өрөө/-ыг сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа иргэн, түүний гэр бүлийн гишүүдийг;

6/"сууц өмчлөгч" гэж нийтийн зориулалттай орон сууцны байшингийн сууц /нэг буюу нэгээс дээш өрөө/ болон тухайн байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу хувьчлан авсан иргэн, түүний гэр бүлийн гишүүдийг;

7/"хуулийн этгээдийн эзэмшлийн орон сууц" гэж тухайн хуулийн этгээдийн гайдан, балансад бүртгэлтэй, түүний ашиглалт, засвар, үйлчилгээний бүх зардал болон сууц эзэмшигчидтэй хийх гэрээ, төлбөр тооцоог уг хуулийн этгээд нь бүрэн хариуцан гүйцэтгэдэг орон сууцыг.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

4 дүгээр зүйл. Орон сууц хувьчлах зарчим

1. Орон сууц хувьчлахад нийтийн зориулалттай орон сууцны байшингийн /шалшид "орон сууц" гэх/ нэг сууц /өрөө/-ыг түүнийг эзэмшигчдэд тухайн орон сууцны дунайн өмчлөлийн эд хөрөнгөөс ногдох хэсгийн хамт сайн дурын нь үндсэн дээр, нэг удаа үнэгүй, зөвхөн орон сууцны зориулалтаар, хувьчлах ажлыг төр, олон нийтийн хяналтын дор ил тод явуулах зарчмыг баримтална.

2. Сууц эзэмших эрхийн бичиг /ордер/-ийн үндсэн дээр нэгтгээс дээш сууц /хэд хэдэн сууцыг нэгтгэж нэг сууцны зориулалтаар өөрчилсөн/ эзэмшиж байгаа нөхцөлд тухайн орон сууцны анхны зургаар сууцны тоог тодорхойлж, сууц эзэмшигчийн хүсэлтээр нэг сууцыг нь үнэгүй, үлдэх сууцыг нь энэ хуульд заасан сууцны үнэлгээгээр үнэтэй хувьчлах зарчмыг баримтална.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5 дугаар зүйл. Хуулийн үйцгээх хүрээ

1. Энэ хууль төрийн өмчийн орон сууцыг хувьчлахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад үйлчилнэ.

2. Орон нутгийн өмчийн орон сууцыг хувьчлах тухай шийдвэрийг тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана. Орон нутгийн өмчийн орон сууцыг хувьчлахала энэ хуульд заасан зарчим, журмыг баримтална.

/Энэ хэсгийн 2 дахь өгүүлбэрийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6 дугаар зүйл. Хувьчлах орон сууц

1. Төрийн өмчийн нийтийн зориулалттай дор дурдсанаас бусад орон сууц хувьчлалд хамаарагдана:

1/Монгол Улс дахь гадаад улсын болон олон улсын байгууллагын жилтнуудад зориулан түрээслэсэн орон сууц;

2/гадаад улс дахь Монгол Улсын төрийн өмчийн орон сууц;

3/цэргийн хуаран дахь орон сууц, нийтийн байр;

4/оюутан, сурагчдын болон улсын асрамж, түүнтэй адилтгах зориулалттай нийтийн байр;

5/төрийн тусгай албыг тодорхой хугацаагаар хашихаар томилогдсон төрийн тусгай албан хаагчдад зориулсан нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь сууцыг.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалтыг Засгийн газар батална.

3. Төрийн өмчит хуудийн этгээдийн эзэмшлэд байгаа орон сууцыг энэ хуудийн дагуу хувьчлах тухай шийдвэрийг Засгийн газар зргэх бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ тухайн хуудийн этгээдийн

саналыг харгалзан үзнэ. Шиндээр гарсан тухайн бүр Төрийн өмчийн хороо уг орон сууцыг хувьчлах ажлыг зохион байгуулна.

4.Төрийн өмчийн оралцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон сууц хувьчлах тухай шийдвэрийг тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллага /гшдүүдийн хурал/ гаргах бөгөөд ингэхүү хувьчлахдаа энэ хуульчлаасан зарчим, журмыг баримтлана.

5.Хувьчлах төрийн өмчийн орон сууц нь хүн гаж төрөх шаардлагыг хангасан байвал зохино.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7 дугаар зүйл.Орон сууц хувьчлан авах эрх

1.Хувьчлах орон сууцыг сууц эзэмшигч эрхийн бичиг /ордер/-ийн үндсэн дээр орон сууц хангах гэрээгээр эзэмшиж байгаа Монгол Улсын иргэн, түүний гэр бүлийн гишүүд тухайн сууцаа хувьчлан авах эрхтэй.

2.Нэг гэр бүл амьдрахад зориулагдсан сууцыг Монгол Улсын хэд хэдэн гэр бүл сууц эзэмшигч эрхийн бичиг /ордер/-ийн үндсэн дээр эзэмшиж байгаа бол гэр бүл тус бүр өөрийн эзэмшиж байгаа өрөө болон тухайн сууцны дундын өмчлэлийн эд хөрөнгөөс өөрт ногдох хэсгийг хувьчлан авах эрхтэй.

3.Зохиу байгууллагын шийдвэрээр нэг гэр бүл амьдрахад зориулагдсан сууцыг Монгол Улсын хэд хэдэн гэр бүл эзэмшиж байгаа бөгөөд тухайн сууцыг эзэмшигч эрхийн бичиг /ордер/ нь нэг сууц эзэмшигчийн нэр дээр, бусад сууц эзэмшигчид нь гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа бол энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хувьчлан авах эрхтэй.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

8 дугаар зүйл./Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Орон сууц хувьчлах ажлын удирдлага, зохион байгуулалт

9 дүгээр зүйл.Төрийн өмчийн хорооны бүрэн эрх

Төрийн өмчийн хороо орон сууц хувьчлах талар дараахь бүрэн эрхтэй:

1/төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих;

2/орон сууц хувьчлах товчоог аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн аймаг, нийслэл, сум, дүүрэгт байгуулах, татан буулгах;

3/орон сууц хувьчлах товчооны ажлдах журмыг энэ хуульд нийцүүлэн тогтоох;

4/орон нутгийн өмчийн орон сууцыг хувьчлах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүдэх;

5/орон сууц хувьчлахтай холбогдож гарсан гомдол, маргааныг энэ хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх.

10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төрийн өмчийн орон сууцыг хувьчлах талаар дараахь бүрэн эрхтэй:

1/орон сууц хувьчлах үүрэг бүхий орон сууц хувьчлах товчоог аймаг, нийслэл, сум, дүүрэгт байгуулах талаар Төрийн өмчийн хороотой зөвшилцөх;

2/нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлын талаар мэдээлэл авах, хэрэгжилтэд хяналт тавих;

3/орон сууц хувьчлах товчоог ажлын байрлаар хангах;

4/нутаг дэвсгэрийнхээ орон сууц ашиглалтын байгууллагыг орон сууц хувьчлах бэлтгэл ажил хангахад татан оролцуулах;

5/орон сууц хувьчлахтай холбоотой асуудлаар орон сууцны асуудал харуулсан төрийн захиргааны төв байгууллагыг болон холбогдох бусад байгууллагад санал оруулах;

6/хуульд заасан бусад бүрэн эрх.

10¹ дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Орон сууцыг хувьчилсны дараахь төрийн өмчийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, ажлын харилцан уялдааг зохицуулна.

2. Орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, засвар, үйлчилгээний норм, стандарт, бусад эрхийн асуудлыг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавина.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/

11 дүгээр зүйл. Орон сууц хувьчлах товчооны бүрэн эрх

Орон сууц хувьчлах товчоо орон сууц хувьчлах ажлыг хэрэгжүүлэхдээ дараахь бүрэн эрхтэй.

1/тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд орон сууцны хувьчлалд хамаарах төрийн өмчийн орон сууцны байшин, сууцны тооллого хийж бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, хувьчлах орон сууц бүрт матадлын шинжилгээний дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах;

/Энэ заалтыг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2/эзэмшиж байгаа сууцаа хувьчлан авах тухай иргэнээс гаргасан өргөдлийг хүлээн авах;

3/орон сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээ болон орон сууц эзэмшигчийн гэр бүлийн гишүүдийн иргэний бичиг баримт, бүртгэл, түүнчлэн сууцны хөлс төлөлтийг шалгаж, зөрчлийг арилгуулах;

4/сууц эзэмшигчийн тодорхойлсон сууцны талбай, үнэлгээг хянаж, хувьчлагдах сууцны талбай, үнэлгээг батлах;

/Энэ заалтыг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5/хувьчлалда хамаарах орон сууц бүрийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тооллого хийж, бүртгэл хөтлөх, шаардлагатай засвар, үйлчилгээ хийлгүүлж, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангуулах арга хэмжээ авах;

/Энэ заалтыг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6/өмчлөх эрхийн гэрчилгээ олгох;

7/орон сууц хувьчлахтай холбоотой хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг сурталчлах ажлыг зохион байгуулах, иргэдэд зөвлөлтгөө өгөх;

8/орон сууц хувьчлахтай холбоотой гомдлыг хүлээн авч, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;

9/орон сууц өмчлөгчдийн холбоо байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлэх;

10/орон сууц хувьчлах явцад орон сууцны цэвэрлэгээ болон дундын эзэмшлийн зүйлсийн ашиглалт, хамгаалалтыг хэвийн байлгах талаар орон сууц ашиглалтын байгууллагатай хамтран ажиллах;

11/төрийн өмчийн орон сууцыг хувьчлахаас өмнө эрх бүхий байгууллагаас худалдаж авсан букоу үнийн зохих хувийг төлсөн Монгол Улсын иргэнд уг сууцыг худалдах тухай шийдвэр, сууцны үнийг төлсөн баримт, бусад материалыг үндэслэн өмчлөх эрхийн гэрчилгээ олгох;

/Энэ заалтыг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

12/хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Сууц хувьчлан авах иргэдийн үүрэг

Хууль ёсоор эзэмшиж байгаа сууц /орон/-аа хувьчлан авах иргэн дор дурдсан үүрэг хүлээнэ:

1/сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээ, иргэний бичиг баримтаа ямар нэг зөрчилгүй байлгах;

2/сууцныхаа хөлсийг бүрэн төлсөн байх;

3/сууцныхаа нийт болон сууцны талбай, үнэлгээг энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлж орон сууц хувьчлах товчоонд гаргаж өгөх;

4/сууцлаа үнэтэй хувьчлан авах тохиолдолд сууцны төлбөрийг хутагаанд нь төлөх;

5/хуульд заасан бусад үүрэг.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

12¹ дүгээр зүйл. Сууц хувьчлан авах иргэдийн эрх

Хууль ёсоор эзэмшиж байгаа сууц /өрөө/-аа хувьчлан авах иргэд дор дурдсан эрх эдэлнэ:

1/эзэмшиж байгаа сууц /өрөө/-аа хувьчлан авах тухай өргөдлийг орон сууц хувьчлах товчоонд гаргах;

2/эзэмшиж байгаа нэг сууц /өрөө/-аа нэг удаа үнэгүй хувьчлан авах;

3/тухайн орон сууцны талаар гарсан магадлан шинжилгээний хэсгийн дүгээлттэй танилцах, түүний талаарх гомдол, магадлан шинжилгээ дахин хийлгэх тухай хүсэлтээ орон сууц хувьчлах товчоонд гаргах;

4/хуульд заасан бүрэн эрх.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Орон сууц хувьчлах

13 дугаар зүйл. Магадлан шинжлэх хэсэг

1. Төрийн өмчийн хороо, аймаг, нийслэлийн Засаг даргын сэмгэн шийдвэрээр хувьчлах орон сууцны чанар, авьяарь, осолгүйн байдал, ариун цэвэр, эрүүд ахуйн болон техникийн шаардлага сангасан эсэхийг тогтоож, тухайн орон сууц хүн амьдрах шаардлага сангаж байгаа эсэх талаар дүгээлт гаргах бүрэн эрхтэй орон тооны бус магадлан шинжлэх хэсгийг байгуулна.

2. Магадлан шинжлэх хэсэг нь орон сууцны ашиглалт, дулаан, дахилгаан, эрчим хүч, гал, ариун цэвэр, барилгын техникийн сангалтын эрх бүхий байгууллага болон хэрэгслэгчдийн эрх ашгийг сангаалах олон нийтийн байгууллага, сууц эзэмшигчдийн төлөөлөгчөөс бүрдэнэ.

/Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3. Магадлан шинжилгээний хэсгийн ажиглах журмыг Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

14 дүгээр зүйл. Магадлан шинжлэх хэсгийн дүгнэлт

1. Магадлан шинжлэх хэсэг тухайн орон сууц хүн амьдрах шаардлага хангасан эсэх талаар дүгнэлт гаргана.

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга магадлан шинжлэх хэсгийн дүгнэлтийг үндэслэн хүн амьдрах шаардлага хангасан болон үл хангасан орон сууцны жагсаалтыг баталж, нийтэд мэдээлнэ.

15 дугаар зүйл. Хувьчлах сууцны талбайг тодорхойлох

1. Хувьчлах сууцны талбайг тухайн сууцны нийт талбайгаар тодорхойлно.

2. Нийт талбайд сууцны бүх өрөө /ажлын, амралтын, гал зуух, ариун цэврийн, угаалгын/ болон өрөө хоорондын хонгил, агуулахын талбай хамларна.

16 дугаар зүйл. Хувьчлах сууцны үнэлгээ, түүнийг тодорхойлох талбай

1. Хувьчлах сууцны үнэлгээг тодорхойлох талбайг сууцны талбайгаар тогтооно.

2. Хувьчлах сууцны нийт талбайгаас гал зуух, угаалга, ариун цэврийн өрөө болон өрөө хоорондын хонгил, агуулахын талбайг хасч сууцны талбайг тодорхойлно.

3. Хувьчлах сууцны анхдагч үнэлгээг тогтооходоо сууцны талбайг нэг ам метр талбайн суурь үнэ /тухайн сууцны нийт талбайн болон дундын өмчлөлийн зүйлсийн үнэлгээний нийлбөр/-ээр үржүүлнэ.

4. Хувьчлах сууцны 1 ам метр талбайн суурь үнэ 150000 төгрөг байна.

/Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5. Хувьчлах сууцны анхдагч үнэлгээнд дараахь итгэлцүүрийг хэрэглэж сууцны үнэлгээг тогтооно:

№	Үзүүлэлтүүд	Хэрэглэх итгэлцүүр
1.	1 Байршил	
	а/Улаанбаатар хот	
	1 дүгээр бүс	1.00
	2 дугаар бүс	0.50
	3 дугаар бүс	0.60
	б/Орхон аймгийн төв	0.40
	в/Дархан-уул, Дорнод аймгийн төв	0.30
	г/Бусад аймгийн төв	0.20
	д/Бусад	0.10

2.	П.Ашиглалтын хугацаа 10 хүртэл жил 10-20 жил 20-ноос дээш жил	1.00 0.80 0.60
3.	Ш.Ханын материалын төрөл тоосгон угсармал төмөр бетон модон бусад	1.00 0.90 0.80 0.75
4.	1Y.Давхарын ялгаа 2-6 дугаар давхарт байрладаг 1 дүгээр давхар болон 7-оос дээш давхарт байрладаг	1.00 0.97
5.	Y.Төхөөрөмжлөгдсөн байдал төвлөрсөн халаалт, халуун, хүйтэн устан халуун усгүй хүйтэн усгүй төвлөрсөн халаалтгүй	1.00 0.97 0.95 0.90

6.Хэд хэдэн итгэлцлүүр нэг зэрэг хэрэглэхээр байвал тэдгээрийг хооронд нь үржүүлд, ерөнхий итгэлцлүүр гаргана.

7.Улаанбаатар хотын Их тойрог дотор байгад бүх орон сууц 1 дүгээр бүсэд; 1, П, Ш, 1Y, X, XIII, XIY, XY, XYI, XIX хороолол, YI бичил хороолол болон 120 мянгатын орон сууц 2 дугаар бүсэд; 1, 2 дугаар бүсэд хамаарагдахгүй болон Улаанбаатар хотын дагуул хот, алслагдсан дүүрэгт байгаа орон сууц 3 дугаар бүсэд тус тус хамаарна.

8.Сууц эзэмшигч хувьчлан авах сууцныхаа үнэлгээг энэ хуульд заасан журмын дагуу тодорхойлж, үнийн талаарх саналаа орон сууц хувьчлах товчоонд гаргана.

9.Орон сууц хувьчлах товчоо сууц эзэмшигчийн гаргасан саналыг харгалзан хувьчлах сууцны үнэлгээг сууц тус бүрээр гаргаж батална.

16¹ дүгээр зүйл. Сууц хувьчлан авах тухай өргөдөл гаргах

1.Сууц хувьчлан авах тухай өргөдлийг дор дурдсан этгээд гаргаж болно:

1/ сууц эзэмших эрхийн бичиг /ордер/-ийн эзэмшигч;

2/энэ зүйлийн 1-д заасан иргэн нас барсан, уг сууц /өрөө/-наас гарсан, иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж шүүх тооцсон, эрхийн бүрэн чадамжийг нь шүүх хязгарласан, цэргийн

жинхэнэ албанд татагдсан, гадаадад зорчих, цагаачлахаар явсан, хорих ял эдэлж байгаа бол гэр бүлийн нь 18 нас хүрсэн аль нэг гишүүн;

3/Энэ зүйлийн 1-д заасан иргэн ам бүл ганцаараа бөгөөд иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамж /эрхийн бүрэн чадамжтай гэж шүүх зарлаагүй бол/-гүй, эрхийн бүрэн чадамж нь шүүхээр хязгаарлагдсан бол харгалзан дэмжигч нь, эрхийн бүрэн чадамжгүй гэж шүүхээр тооцогдсон бол асран хамгаалагч нь, цэргийн жинхэнэ албанд татагдсан, гадаадад зорчих, цагаачлахаар явсан, хорих ял эдэлж байгаа болон эрүүл мэндийн байдлаас шалтгаалан эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй бол тухайн иргэний зөвшөөрлөөр итгэмжлэгдсэн төлөөлөгч.

2.Сууц хувьчлан авах тухай өргөдлийг орон сууц хувьчлах товчоонд гаргана.

3.Өргөдөлд сууц /өрөө/ эзэмшигчийн овог, нэр, ажлын ба гэрийн хаяг, эрхэлсэн ажил, албан тушаал, иргэний паспортын болон регистрийн дугаар, орон сууц эзэмших эрхийн бичиг /ордер/ний дугаар, олгосон байгууллага, он, сар, өдөр, ам бүлийн тоо, гэр бүлийн гишүүдийн овог нэг, төрсөн он, сар, өдөр, иргэний паспортын болон регистрийн дугаар, насанд хүрээгүй хүмүүсийн төрсний гэрчилгээний дугаар, эзэмшиж байгаа сууцаа хувьчлан авах тухай хүсэлтээ бичиж өргөдөл гаргагч гарын үсгээ зурж, он сар, өдрөө бичнэ.

4.Эзэмшиж байгаа сууц /өрөө/-ныхаа нийт болон сууцны талбай, үнэлгээг энэ хуульд заасан журмын дагуу тодорхойлж үнийн талаархи саналын хамт өргөдөлд хавсаргана.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/

17 дугаар зүйл.Сууц хувьчлах тухай шийдвэр гаргах

1.Орон сууц хувьчлах товчоо сууц эзэмшигчийн өргөдлийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор тухайн сууцыг хувьчлах нөхцөл хангагдсан эсэхийг хянаж, сууц тус бүрээр хувьчлах тухай шийдвэр гаргана.

2.Хувьчлах нөхцөл хангаагүй сууцны талаарх өргөдлийг сууц эзэмшигчид буцаах бөгөөд уг этгээд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1,2 дахь заалтад заасан үүргийг хангасны дараа дахин өргөдөл гаргах эрхтэй.

18 дугаар зүйл.Өмчлөх эрхийн гэрчилгээ

1.Сууц хувьчлах тухай шийдвэрийг үндэслэн сууц эзэмшигчид тухайн сууцыг өмчлөх эрхийн гэрчилгээ олгоно.

/Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2.Өмчлөх эрхийн гэрчилгээнд дараахь зүйлийг заавал тусгана:

1/Өмчлөгч /дундаа хамтран өмчлөх эрх бүхий этгээд/-ийн овог, нэр, регистрийн дугаар;

2/орон суушны байршил, хаяг;

3/орон сууц хувьчлах тухай шийдвэрийн он,сар,өдөр, дугаар, сууцны үнэлгээ /тогтоогоор/;

/Энэ заалтыг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

4/үнэтэй хувьчилсан сууцны үнэлгээний хэмжээ;

/Энэ заалтыг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5/үнэтэй хувьчлах сууцны үнийг ямар хэлбэрээр төлсөн тухай.

/Энэ заалтыг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.Өмчлөх эрхийн гэрчилгээний загвар, олгох журам, үнийг Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

19 дүгээр зүйл./Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

20 дугаар зүйл. Үнэтэй хувьчлах суушны үнийг

төлөх хэлбэр, хугацаа.

1.Үнэтэй хувьчлах суушны үнийг дараахь хэлбэрээр төлнө:

1/бэлэн ба бэлэн бус мөнгөн хэлбэрээр;

2/нэрлэсэн үнээр нь тооцсон хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн ягаан тасалбараар.

2.Үнэтэй хувьчлах суушны төлбөрт оруулан тооцох ягаан тасалбарын тоонд хязгаар тогтоохгүй.

3.Үнэтэй хувьчлах суушны үнийг тухайн сууцыг хувьчлах тухай шийдвэр гарснаас хойш нэг жилийн дотор төлнө.

4.Үнэтэй хувьчлах суушны үнийг тогтоосон хугацаанд төлөөгүй бол тухайн сууцыг хувьчлах тухай шийдвэр хүчингүй болно.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

21 дүгээр зүйл./Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

22 дугаар зүйл. Үнэтэй хувьчлах сууцны

төлбөрийн орлого

Үнэтэй хувьчлах сууцны төлбөрөөс орсон орлогыг улсын төвлөрсөн төсвийн тусгай дансанд төвлөрүүлж, орон сууц хувьчлахтай холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

/Энэ зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Орон сууц хувьчлахтай холбоотой гарсан гомдол, маргааныг шийдвэрлэх

23 дугаар зүйл. Гомдол гаргах

1. Сууц эзэмшигч сууц хувьчлахтай холбоотой гомдлыг орон сууц хувьчлах товчоонд гаргах ба товчоо уг гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

2. Сууц эзэмшигч орон сууц хувьчлах товчооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн өмчийн хороонд гомдол гаргаж болно. Төрийн өмчийн хороо уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө.

3. Орон сууц хувьчлах товчооны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Төрийн өмчийн хороонд гаргах ба Төрийн өмчийн хороо уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4. Тухайн этгээд Төрийн өмчийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

5. Орон сууц эзэмших эрхтэй холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хувьчлагдсан сууцыг өмчлөх эрх үүсэх, түүнийг зохицуулах

24 дүгээр зүйл. Хувьчлагдсан сууцыг өмчлөх эрх үүсэх

Хувьчлагдсан сууцыг өмчлөх эрх нь сууц өмчлөх эрхийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үүснэ.

25 дугаар зүйл. Хувьчлагдсан сууцыг өмчлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах

1. Сууц өмчлөгчийн тухайн сууц /өрөө/-ыг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг Иргэний хуулийн 94-99 дүгээр зүйлд засны дагуу зохицуулна.

2. Хувьчлагдсан сууцны өрөөнүүдийг нэгээс дээш гэр бүл өмчилж байгаа бол тухайн сууцны дундын эзэмшлийн эд хөрөнгө /гал зуух, ариун цэврийн өрөө, агуулах, сууцны тагт, өрөө хоорондын талбай, сууцны тагт зэрэг/-ийг дундаа хамтран өмчилнө. Уг эд хөрөнгийг хоорондоо харилцан тохиролцсоны дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна. Үүнтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

/Энэ бүлгийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж
зөрчигчдэд хүлээлтэй харьцуулага

26 дугаар зүйл. Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж
зөрчигчдэд хүлээлтэй харьцуулага

1. Албан тушаалтан орон сууц хувьчлах ажилд эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, бүрэн эрхээ хэтрүүлсэн, хайнга хандсан, хээл хахууль авсан, өгсөн, зуучилсан, хуурамч баримт бичиг үйлдсэн гэм буруутай бол Эрүүгийн хуульд заасны дагуу харьцуулага хүлээнэ.

2. Орон сууц хувьчлахтай холбогдуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол түүнд учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлнө.

3. Сууц хувьчлан авахтай холбогдсон баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлтэйгээргүй бол шүүх 10000-50000 төгрөгөөр торгоно.

/Энэ бүлгийг 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууднаар нэмсэн/

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ОРОН СУУЦНЫ
ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь дундын өмчлөлийн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийг сууц, тухайн орон сууцны сууцны бус зориулалттай хэсгийг өмчлөгчид /цаашид энэ хуульд "сууц өмчлөгч" гэх/ дундаа хамтран өмчлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах, орон сууц өмчлөгчдийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино.

/Энэ зүйлийг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2 дугаар зүйл. Дундын өмчлөлийн орон сууцны тухай хууль ТОГТООМЖ

Дундын өмчлөлийн орон сууцны тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Орон сууц хувьчлах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

"1/"дундын өмчлөлийн орон сууц" гэж өмчлөгчид сууц, тухайн орон сууцны сууцны бус зориулалттай хэсгийг дангаараа, дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчилж байгаа дөрөв буюу түүнээс дээш сууцтай нийтийн зориулалттай орон сууцны байшинг;

/Энэ заалтыг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2/"сууц өмчлөгчид оногдох хэсэг" гэж орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардыг санхүүжүүлэх, сууц өмчлөгчдийн холбоог удирдахад тухайн сууц өмчлөгчийн оролцох хувь хэмжээг;

3/"сууцны бус зориулалттай хэсэг" гэж нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь үйлчилгээ, үйлдвэрлэл явуулах зэрэг сууцны бус зориулалтаар ашиглагдаж байгаа хэсгийг.

/Энэ заалтыг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн/

4 дүгээр зүйл. Дундын өмчлөлийн эд хөрөнгө

1. Орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгөд нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууц, хоорондын талбай, түүний тэгт дээвэр, тоног төхөөрөмж, орчны хаалга, довжоо, цонх, хог зайлуулах хоолой, халаалт, халуун, хүйтэн усны удирдах зангилалны анхны хаалт хүртэл, цахилгааны оролтын самбар хүртэл, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэлх, шалны $\pm 0,00$ тэмдэгтээс дээшхи бохир усны шугам сүлжээ хамаарна.

2. Сууц өмчлөгчид нь дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчилнө.

3. Орон сууцны дэвсгэр газрын өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт хэвсгэр дундын өмчлөлийн эд хөрөнгийг нь нэг этгээдийн эзэмшил, ашиглалтад тусгайлан олгохыг хориглоно.

/Энэ зүйлийг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5 дугаар зүйл. Дундын өмчлөлийн эд хөрөнгийн талаар гарсан зардлыг хуваарих

1. Орон сууцны цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууц хоорондын талбай, түүний тагт, орчны халга, довжоо, цонх, хог зайлуулах хоолойн засвар, үйлчилгээтэй холбогдсон, түүнчлэн өөр нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлохдоо уг зардлыг тухайн орон сууцны нийт сууцны тоонд хуваана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээ болон их засвартай холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд сууц, сууцны бус зориулалттай хэсгийг өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлохдоо түүний өмчлж байгаа сууц, сууцны бус зориулалттай хэсгийн талбайг тухайн орон сууцан дахь сууц, сууцны бус зориулалттай хэсгийн нийт талбайн нийлбэрт харьцуулсан харьцаагаар тодорхойлно.

3. Хувьцалдсан орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн их засвар зориулан төрөөс захир хууль тогтоомжийн дагуу сууц өмчлөгчдийн холбоонд хөнгөлөлттэй, удаан хугацааны зээл олгож болно.

4. Сууц өмчлөгчдийн холбоо нь дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу талууд хариуцна.

5. Сууц өмчлөгч нь өөрийн өмчлөлд байгаа сууц болон сууцны бус зориулалттай хэсгийн ашиглалтын /халаалт, халуун, цэвэр, бохир ус, ариутгал, хог, цахилгаан, холбоо зэрэг/ төлбөрийг эрх бүхий мэргэжлийн байгууллагад, дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг сууц өмчлөгчдийн холбоонд тус тус төлнө.

/Энэ зүйлийг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6 дугаар зүйл. Сууц өмчлөгчдийн холбоо

1. Нийтийн зориулалттай орон сууцны байшинд хоёр буюу түүнээс дээш этгээд сууц өмчлөгч болсон тохиолдолд дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, тухайн орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор сууц өмчлөгчдийн холбоо /цаашид "холбоо" гэх/ байгуулна.

/Энэ хэсгийг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2.Холбоо нь зөвхөн тухайн орон сууцны ашиглалт, хэвийн ажиллагааг хангах зорилгоор үйл ажиллагаа явуулах ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

Холбоо нь тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

3.Холбоог зохион байгуулах хурлын шийдвэрийг үндэслэн Хууль зүйн яам улсын бүртгэлд бүртгэх бөгөөд бүртгүүлсэн өдрөөс эхлэн түүнийг байгуулагдсанд тооцно.

4.Тухайн орон сууцанд оршин суугаа сууц өмчлөгч, сууцны бус зориулалтын хэсгийг өмчлөгч бусад этгээд тухайн орон сууцан дахь холбооны гишүүн заавал байна.

Орон сууцны бүрэлдэхүүнд төрийн өмчийн сууц байгаа бол төрийн эрх бүхий байгууллагаас томилогдсон төлөөлөгч холбооны гишүүн байж, төрийг төлөөлөн түүний үйл ажиллагаанд оролцоно.

5.Холбоо нь энэ хууль болон дүрэмдээ заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулж болно.

Энэхүү үйл ажиллагааны үр дүнд шинээр олж авсан хөрөнгө тухайн холбооны гишүүдийн дундын өмч болно.

6.Холбоо татан буугдахаас бусад тохиолдолд түүний аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогыг холбооны гишүүдэд аливаа хэлбэрээр хуваарилахыг хориглоно.

7.Холбоо нь гишүүдийн хүлээх үүргийг, гишүүд нь холбооны хүлээх үүргийг хариуцахгүй.

8.Холбоог зохион байгуулах хурлыг сууц өмчлөгчид буюу тухайн нутаг дэвсгэрт байгаа орон сууц хувьчлах товчооны санаачилгаар хийнэ.

/Энэ хэсгийг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн/

7 дугаар зүйл. Орон сууцны бүртгэл

1.Холбоо нь тухайн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн бүртгэлийг зохих журмын дагуу гаргаж, үл хөдлөх хөрөнгө бүртгэх газарт бүртгүүлнэ.

2.Дундын өмчлөлийн эд хөрөнгийн бүртгэлд дор дурдсан зүйлийг тусгана:

1/орон сууцны байшингийн иж бүрэн зураг төсөл;

2/сууц бүрийн дугаар, нийт талбайн хэмжээ, өрөөний тоо, сууц өмчлөгчдийн овог, нэр, регистрийн дугаар;

3/тухайн орон сууцан дахь сууцны бус зориулалттай хэсгийг өмчлөгчийн овог, нэр, регистрийн дугаар, түүний өмчилж байгаа хэсгийн талбайн хэмжээ;

4/дундын өмчлөлийн эд хөрөнгийн бүртгэл, дэвсгэр газрын хэмжээ.

/Энэ зүйлд 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

8 дугаар түйм. Сууц өмчлөгчийн эрх, үүрэг

1. Сууц өмчлөгч нь дараахь үүрэг хүлээнэх:

1/энэ хууль болон холбооны дүрмийг сахин биелүүлэх;

2/гншүүдийн хурлын шийдвэрийг биелүүлэх;

3/дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон болон бусад нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу оролцох.

Сууц, сууцны бус зориулалттай хэсгийг ашиглахгүй байх буюу дундын өмчлөлийн эд хөрөнгийг ашиглахаас татгалзах нь тухайн сууц өмчлөгчийг дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардалаас хэсэгчлэн буюу бүрэн чөлөөлөх үндэслэл болохгүй.

4/сууц, сууцны бус зориулалттай хэсгийг ашиглах, түүнд засвар, өөрчлөлт, шинэчлэл хийхдээ архитектур, барилгын үндсэн бүтэц, экологи, эрүүл ахуй, галын аюулгүй байдлын болон орон сууцны ашиглалтын талаархи хууль тогтоомж, норм, стандартад заасан шаардлагыг сахин биелүүлэх, бусад орон сууц өмчлөгчдийн эд хөрөнгөд хохирол учруулахгүй, хууль ёсны бусад эрх, ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

5/сууцныхаа доторхи засвар, үйлчилгээний бүх зардлыг хариуцах, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагаас үзүүлсэн сууцны үйлчилгээний хөлсийг төлөх;

6/хэрэв сууц, сууцны бус зориулалттай хэсгийг ашиг олох зорилгоор бусдад ашиглуулж байгаа бол хуулиар тогтоосон татвар төлөх;

7/өөрийн болон гэр бүлийн гншүүдийн, түүнчлэн орон сууц хөлслөх гэрээний дагуу орон сууц өмчлөгчөөс олгосон ямар нэг эрхийн үндсэн дээр сууцыг нь эзэмшиж байгаа эгтээд бусдын сууцанд болон дундын өмчлөлийн эд хөрөнгөд хохирол учруулбал түүнийг өөрийн хөрөнгөөр арилгах.

8/сууц, сууцны бус зориулалттай хэсгийг нь орон сууц хөлслөх, эд хөрөнгө түрээслэх гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа эгтээд гэрээнд заасан бол энэ хуулийн 5-д заасан зардал, хөлсийг хугацаанд нь төлөөгүйн хариуцлагыг хүлээх.

9/хуульд заасан бусад үүрэг.

2. Сууц өмчлөгч дараахь эрх эдэлнэ:

1/сууцдаа гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулан энэ хууль, хууль тогтоомжийн бусад акт болон холбооны дүрэмд заасан журмыг баримтлан эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

2/холбоо болон бусад сууц өмчлөгчдөөс зөвшөөрөл авахгүйгээр өөрийн сууц, сууцны бус зориулалттай хэсгээ захиран зарцуулах;

3/сууц, сууцны бус зориулалттай хэсгийг худалдахдаа үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх талаар тогтоосон журмыг баримтлаа;

4/хуульд заасан бусад эрх.

/Энэ зүйлийг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9 дүгээр зүйл. Холбооны дүрэм

1.Холбооны дүрэмд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1/холбооны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

2/холбооны зорилго, үйл ажиллагааны чиглэл;

3/холбооны удирдах болон хянан шалгах байгууллагын бүтэц, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ;

4/холбоо болон сууц өмчлөгчдийн эрх, үүрэг;

5/дундын өмчлөлийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам;

6/сууц өмчлөгч бүрээс дундын өмчлөлийн хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд оролцох журам;

7/холбооны үйл ажиллагаана шаардлагатай хөрөнгө бүрдүүлэх, сан байгуулж ашиглах журам;

8/холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах журам.

/Энэ хэсэгт 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2.Холбооны дүрмийг гишүүдийн хурлаар хэлэлцэж батална.

3.Холбооны үлгэрчилсэн дүрмийг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

10 дугаар зүйл. Холбооны эрх барих байгууллага

1.Холбооны эрх барих дээд байгууллага нь гишүүдийн хурал байна.

2.Дор дурдсан асуудлыг заавал гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

1/холбооны дүрэм, дотоод журам батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

/Энэ заалтыг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2/холбооны төсөв, баланс, тайлан хэлэлцэж батлах, орон сууцны хэвийн ажиллагааг хангах зорилгоор сан байгуулж ашиглах;

3/дундын өмчлөлийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаархи захирлын эрх хэмжээг тогтоох;

/Энэ заалтад 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4/захирлыг сонгох, чөлөөлөх, опирлуулах, түүнд олгох хөлс, урамшууллын хэмжээг тогтоох, түүний тайланг хэлэлцэх, захирлын үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэх;

/Энэ заалтыг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5/хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-ийг сууц өмчлөгчдөөс сонгож, тэдгээрт олгох урамшууллын хэмжээг тогтоох, тайланг хэлэлцэх, тэдний үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэх;

/Энэ заалтыг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6/хууль, дүрэмд заасан бусад асуудал.

11 дүгээр зүйл. Гишүүдийн хурал, түүний хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

1.Сууц өмчлөгчид оногдох хэсгийн 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа сууц өмчлөгчид оролцсоноор гишүүдийн хурал хүчин төгөлдөр болно. Гэхдээ хэлэлцэх асуудлын төрөл, холбооны гишүүдийн тоо зэргийг харгалзан холбооны дүрэмд хуралд оролцох гишүүдийн тооны доод хязгаарыг зааж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьд хүрээгүй бол гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж, дахин хуралдуулах өдрийг товлоно. Дүрэмд өөрөөр заагаагүй бол дахин зарласан хурал энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болно.

Ээлжит бус хуралд гишүүн заавал биечлэн оролцоно.

3.Гишүүдийн хуралд оролцогч сууц өмчлөгчид оногдох хэсгийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

12 дугаар зүйл. Гишүүдийн хурал хуралдуулах журам

1.Гишүүдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

Дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүдийн ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

2.Гишүүдийн ээлжит бус хурлыг захирал, хянан шалгагч (хянан шалгагчдын зөвлөл)-ийн санаачилгаар буюу сууц өмчлөгчид оногдох хэсгийн гуравны нэгээс дээш хувийг эзэмшиж байгаа сууц өмчлөгчдийн шаардсанаар зарлан хуралдуулна.

3.Гишүүд хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг гишүүдийн хуралд оролцсон гэж үзнэ.

4.Хурлаас тогтоол, хурлын тэмдэглэл гаргах бөгөөд түүнд хурал даргалагч гарын үсэг зурж, холбооны тэмдгээр баталгаажуулна.

5.Гишүүдийн хурлын товыг хурал хуралдуулахаас 14 хоногийн өмнө гишүүдэд зарлаж, гишүүдийн хурлаас гарах шийдвэрийн төслийг бичгээр мэдэгдэнэ.

6.Товлоогүй асуудлыг зөвхөн хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн зөвшөөрснөөр хэлэлцэж болно.

7.Гишүүдийн хурлыг захирал удирдана. Хэрэв захирлаар удирдуулах бололцоогүй гэж үзвэл хуралд оролцогчдын олонхийн саналаар аль нэг сууц өмчлөгчийг хурал удирдуулахаар сонгоно.

8. Гишүүн өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр гишүүдийн хуралд оролцуулж болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа гишүүдийн хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.

9. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй байна. Гишүүдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.

13 дугаар зүйл. Захирал

1. Гишүүдийн хурлын чөлөө цагт холбооны өдөр тутмын үйл ажиллагааг холбооны дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд захирал удирдана.

2. Дүрэмд өөрөөр заагаагүй бол захирлаар холбооны гишүүн бус хүнийг сонгож болно.

3. Захирал дараахь эрх эдэлж, үүрэг хүтээнэ:

1/дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг холбооны дансанд төвлөрүүлэх;

2/холбооны дүрэмд өөрөөр заагаагүй бол орон сууцны засвар, үйлчилгээ хийлгэх, орон сууцны хэвийн ажиллагааг хангах талаар үйлчилгээний мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

3/холбооны мөнгөн хөрөнгийг түүний зорилго, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн энэ хууль болон холбооны дүрэмд тогтоосон эрх хэмжээний дотор зөвхөн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээнд зориулан захиран зарцуулах;

4/энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөн сууц өмчлөгчөөр төлбөр гаргуулах, эсхүл хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;

5/дундын өмчлөлийн эд хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглуулах талаар гэрээг холбооны нэрийн өмнөөс байгуулах;

6/холбооны нэрийн өмнөөс буюу хоёроос доошгүй сууц өмчлөгчийн хүсэлтээр эрх бүхий байгууллагад асуудал тавих;

7/гишүүдийн болон гишүүдийн хурлын хянан шалгагч (хянан шалгагчдын зөвлөл)-ийн шийдвэрийн бүртгэл хөтлөх;

8/хууль, дүрэмд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүтээх.

/Энэ хэсэгт 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4. Захирал жилд нэгээс доошгүй удаа гишүүдийн хуралд ажлаа хариуцан тайлагнана.

5. Захирал эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаархи гишүүдийн хурлаас тогтоосон эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглах зэрэг захирлын гэм буруутай үйл ажиллагаанаас

тухайн холбоонд хохирол учирсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

14 дүгээр зүйл. Холбооны санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт

1. Захирал болон холбооны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хянан шалгагч (хянан шалгагчдын зөвлөл) гүйцэтгэнэ.

2. Хяналтын үүргийг зөвхөн нэг этгээд гүйцэтгэж байгаа бол түүнийг хянан шалгагч, харин хэд хэдэн этгээд хяналтын үүрэг гүйцэтгэхээр бол хянан шалгагчдын зөвлөл байгуулна.

3. Хянан шалгагчдын зөвлөл сууц өмчлөгчдөөс бүрдэнэ.

15 дугаар зүйл. Хянан шалгагчийн эрх, үүрэг

1. Хянан шалгагч (хянан шалгагчдын зөвлөл) дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1/захирлын үйл ажиллагаанд хяналт тавих;

2/холбооны үйл ажиллагаа энэ хууль, холбооны дүрэмд заасны дагуу явагдаж байгаа эсэхийг хянах;

3/нягтлан бодох, бүртгэл хөтлөлт, баланс, тайлан гаргалт хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хийгдсэн эсэхийг хянах;

4/эд хөрөнгийн үнэлгээ зөв эсэхийг шалгах;

5/шаардлагатай бол гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах.

2. Хянан шалгагч шалгасан баримт бичиг, баланс, тайлангийн нууцыг хадгалах үүрэгтэй.

16 дугаар зүйл. Хянан шалгагчдын зөвлөлийн хурал, түүний шийдвэр

1. Хянан шалгагчдын олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

2. Хуралд оролцогчдын олонхийн саналаар зөвлөлийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

3. Хянан шалгагчдын зөвлөлийн тавьсан асуудлыг захирал хүлээн авахгүй буюу тодорхой асуудал хэлэлцүүдэхээр гишүүдийн хурал хуралдуулах хүсэлт гаргасныг нь зөвшөөрөөгүй тохиолдолд хянан шалгагчдын зөвлөл гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно.

17 дугаар зүйл. Холбоог татан буулгах

1. Холбоо нь дор дурдсан үндэслэлээр татан буугдана:

1/тухайн орон сууцны бүх сууц нэг этгээдийн өмчид шилжсэн;

2/тухайн орон сууц засч сэргээх боломжгүйгээр эвдэрсэн буюу нурж устсан;

3/татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

2. Холбоог гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор иргэд эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомж

1. Төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бод олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

1. Энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна.

2. Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулдаг олон улсын болон бусад улсын төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газарт нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг;

2/ "нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага" гэж соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг,

давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг;

3/"Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага" гэж өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдэгээс бусад төрийн бус байгууллагыг.

5 дугаар зүйл. Төрийн бус байгууллага байгуулах, оролцох эрх

1.Монгол улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй.

2.Төрийн бус байгууллага байгуулах иргэдийн эрхийг хууль бусаар хягаарлахыг хориглоно.

3.Төрийн бус байгууллагад албадан оруулахыг хориглоно.

4.Төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө хүнийг ялгаварлан гадуурхах, эрх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

5.Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь олон түмэнд ил тод байх ба түүний гишүүд болон иргэд хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болно.

6.Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэд, харьвалалгүй хүмүүс Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан журмын дагуу төрийн бус байгууллага байгуулах буюу төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдэж болно.

6 дугаар зүйл. Төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсанд тооцох

Үүсгэн байгуулагчдаас төрийн бус байгууллага байгуулах тухай шийдвэр гаргаж байгууллагын дүрмийг баталснаар төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсанд тооцох бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

7 дугаар зүйл.Төрийн бус байгууллагыг татан буулгах

1.Төрийн бус байгууллагыг дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан болон дүрэмд нь заасан бусад үндэслэлээр татан буулгаж болно. Ийнхүү татан буулгах тухай шийдвэрийг төрийн бус байгууллагын эрх барих байгууллага гаргана.

2.Татан буулгах төрийн бус байгууллагын зохиц төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм төрийн бус байгууллага байхгүй бол зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

3.Төрийн бус байгууллагын эрх бүхий байгууллага нь түүнийг татан буулгасан тухай шийдвэрээ 21 хоногийн дотор нийгэд мэдээлж Хууль зүйн яаманд бичгээр ирүүлэх бөгөөд энэхүү шийдвэрийг үндэслэн улсын бүртгэлээс хасна.

8 дугаар зүйл.Төрийн бус байгууллагыг албадан татан буулгах

1.Төрийн бус байгууллагыг дор дурдсан үндэслэлээр шүүх албадан татан буулгана:

1/дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан;

2/хууль тогтоомж ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн.

2.Шүүхийн шийдвэрээр албадан татан буугдсан төрийн бус байгууллагын эд хөрөнгийн асуудлыг энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Төрөөс төрийн бус байгууллаагатай

харьцах

1.Төрөөс төрийн бус байгууллагын хууль ёсны эрхийг хамгаална.

2.Төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байна.

3.Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно.

4.Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон төрийн нууцал үл хамраах мэдээлэл төрийн бус байгууллагад нээлттэй байна.

5.Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болно.

6.Төрийн бус байгууллага төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар байр сууриа илэрхийлж мэдэгдэл хийж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

10 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын дүрэм

Төрийн бус байгууллагын дүрэмд дор дурдсан зүйлийг тусгана:

1/ төрийн бус байгууллагын нэр, хаяг;

2/ төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсан он,сар, өдөр;

3/ төрийн бус байгууллагын зорилго;

4/ төрийн бус байгууллагын бүтэц, хяналтын тогтолцоо;

5/ удирдах зөвлөлийн эрх хэмжээ;

6/ удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний доод, дээд хязгаар;

7/удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх журам, бүрэн эрхийн хугацаа;

8/ удирдах зөвлөлийн жилд хуралдах хурлын тооны доод хязгаар;

9/ удирдах зөвлөлийн хуралдааныг хүчинтэйд тооцох ирц;

10/ удирдах зөвлөлийн хуралдаанаас шийдвэр гаргах журам;

11/төрийн бус байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл, журам, энэ тохиолдолд хөрөнгийг хэрхэх тухай ;

12/ дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, журам.

11 дүгээр зүйл.Төрийн бус байгууллагын удирдах

байгууллага

1. Гишүүнчлэлгүй төрийн бус байгууллагын эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/ төрийн бус байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах;

3/ байгууллагын жилийн төсөв батлах;

4/ гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, тайлзныг хэлэлцэх;

5/ төрийн бус байгууллагын өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар гүйцэтгэх захирлын эрх, хэмжээг тогтоох;

6/ төрийн бус байгууллагын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, түүний төсвийг батлах;

7/ дүрэмд заасан бусад бүрэн эрх.

2. Гишүүнчлэлтэй төрийн бус байгууллагын дүрэмд өөрөөр заагаагүй бол түүний эрх барих байгууллага нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрх бүхий удирдах зөвлөл байна.

3. Удирдах зөвлөл нь таваас доошгүй сондгой тооны гишүүдээс бүрдэнэ.

4. Удирдах зөвлөлийн гишүүн нь үүргээ гүйцэтгэх явцад гаргасан зардлын нөхөн төлбөрөөс бусад цалин, аливаа шагнал авахгүй.

12 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлага

1. Дүрэмд өөрөөр заагаагүй бол удирдах зөвлөлийн дарга нь төрийн бус байгууллагыг гадаад, дотоодод төлөөлөх, удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах, удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах зэрэг бүрэн эрхтэй байна.

2. Гүйцэтгэх захирал дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд төрийн бус байгууллагыг төлөөлөх, өмч хөрөнгийг захиран зарцуулах;

2/ хууль, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

3. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хягаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг гэрээгээр зохицуулна.

4. Гүйцэтгэх захирал нь өөрийн бүрэн эрхийн хугацаа дууссан нөхцөлд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл албан үүргээ хэвээр гүйцэтгэнэ.

5. Төрийн бус байгууллагын гишүүн, удирдах зөвлөлийн гишүүн, ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг төрийн бус байгууллага хүлээхгүй.

13 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн шийдвэр гаргах журам

1. Удирдах зөвлөлийн гишүүд /цаашид "гишүүн" гэх/ аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй байна.

2. Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.

3. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж

санал хураалтанд оролцохгүй. Удирдах зөвлөлийн хуралдаан даргалагч сонирхлын зөрчилтэй байвал хуралдааныг өөр гишүүн даргална.

14 дүгээр зүйл. Удирдах зөвлөлийн хуралдааны тэмдэглэл

Удирдах зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ит санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ. Гишүүн тайлбараа биелгээр гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ БҮРТГЭХ

15 дугаар зүйл. Төрийн бус байгууллагыг бүртгэх

Төрийн бус байгууллагыг энэ хуульд заасан журмын дагуу Хууль зүйн яам улсын бүртгэлд бүртгэнэ.

16 дугаар зүйл. Төрийн бус байгууллагыг бүртгэх журам

1. Төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримт бичгийн хамт Хууль зүйн яаманд удирдах зөвлөлийн дарга гаргана.

2. Өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

1/төрийн бус байгууллагын нэр, хаяг;

2/удирдах зөвлөлийн гишүүд, дарга, гүйцэтгэх захирлын нэр, хаяг;

3/удирдах зөвлөлийн даргын гарын үсгээр баталгаажсан төрийн бус байгууллагын дүрэм;

4/ улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай баримт.

3. Төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл, бусад холбогдох баримт бичгийг Хууль зүйн яаманд шууд буюу нутгийн захиргааны байгууллагаар уламжлуулан хүргүүлнэ.

4. Төрийн бус байгууллагыг бүртгэх тухай өргөдөл, бусад холбогдох баримт бичгийг анх хүлээн авсан байгууллага нь тухайн баримт бичгийг хүлээн авсан он, сар, өдрийг төрийн бус байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

5. Улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл, бусад баримт бичгийн бүрдэл дутуу буюу энэ хуулийн 10 дугаар зүйл, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй бол тухайн өргөдлийг анх хүлээн авсан байгууллага нь бүртгүүлэх хүсэлт гаргасан төрийн бус байгууллагад буцаана.

6. Хууль зүйн яам зохих шаардлага хангасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1/төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх;

2/дор дурдсан тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах;

а/тухайн байгууллагын зорилго нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцдэггүй;

6/төрийн бус байгууллагын нэр нь өмнө бүртгүүлсэн төрийн бус байгууллагын нэртэй давхардсан.

7.Хууль зүйн яам төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно. Гэрчилгээний загвар, түүнийг олгох журмыг Хууль зүйн сайд тогтооно.

8.Хууль зүйн яам төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай үндэслэл бүхий албан ёсны хариу өгөх бөгөөд энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомлол гаргаж болно.

9.Төрийн бус байгууллага нь түүнийг бүртгэхээс татгалзсан шалтгааныг арилгасны дараа бүртгүүлэх хүсэлтээ дахин гаргаж болно.

10.Төрийн бус байгууллага нь улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх талаар энэ зүйлийн 6-д заасан хугацаанд Хууль зүйн яамнаас албан ёсоор хариу аваагүй бол хууль ёсоор бүртгүүлсэнд тооцогдож үйл ажиллагаагаа явуулах бөгөөд зохих журмын дагуу бүртгэлийн гэрчилгээг нөхөн авна.

11.Хууль зүйн яам төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэсэн тухай шийтгэл мэдээлнэ.

17 дугаар зүйл. Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх

1.Төрийн бус байгууллагын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ тухай 30 хоногийн дотор Хууль зүйн яаманд мэдэгднэ.

2.Хууль зүйн яам тухайн төрийн бус байгууллагын дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг бүртгэсэн тухай, эсхүл бүртгээгүй бол үндэслэл бүхий албан ёсны хариут 30 хоногийн дотор өгнө.

18 дугаар зүйл. Улсын бүртгэлээс хасах

1.Хууль зүйн яам дор дурдсан үндэслэлээр төрийн бус байгууллагыг улсын бүртгэлээс хасч энэ тухай шийтгэл мэдээлнэ.

1/албадан татан буулгах тухай шүүхийн шийдвэр зүчин төгөлдөр болсон;

2/бичигээр сануулга өгсөн боловч үйл ажиллагааныхаа тайланг гаргаж өгөөгүй.

2.Тухайн төрийн бус байгууллага нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан зөрчлийг арилгасны дараа энэ зауулийн дагуу улсын бүртгэлд дахин бүртгүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ.

19 дүгээр зүйл. Төрийн бус байгууллагын орлого

Төрийн бус байгууллагын орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэж болно:

1/гшишүүний татвар, хандив;

2/иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;

3/дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;

4/хээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө;

20 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын зарлага

1. Төрийн бус байгууллага нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

2. Төрийн бус байгууллагын орлогоос ногдол ашиг хуваарилал, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх зэргийг хориглоно.

3. Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн ажилтнаас тухайн байгууллагын эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4. Төрийн бус байгууллага нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдэд эд хөрөнгө, хандиа өгөхийг хориглоно.

21 дүгээр зүйл. Төрийн бус байгууллагад хөнгөлөлт үзүүлэх

1. Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандиа, гишүүний татвар, өвлүүлсэн хөрөнгө, дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогыг албан татвараас чөлөөлнө.

2. Гишүүдээ үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын гишүүний татвар, хандиваас олсон орлогыг албан татвараас чөлөөлнө.

3. Улсын бүртгэлд бүртгүүлсэн төрийн бус байгууллагад энэ хуульд зааснаас бусад хөнгөлөлт үзүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

22 дугаар зүйл. Хандивлагчид албан татварын хөнгөлөлт үзүүлэх

Хандивлагчийн албан татвар ногдох жилийн орлогоос нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандивын нийт дүнгээр тухайн үеийн зах зээлийн үнийн ханшаар тооцоолон хасч татварын хөнгөлөлт үзүүлнэ. Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад эд хөрөнгө өвлүүлсэн бол өвлүүлэгчийг өв залгамжлалын албан татвараас чөлөөлнө.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

23 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын тайлан

1. Төрийн бус байгууллага нь зохиц журмын дагуу жилийнхээ тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Татварын албанд өгнө.

2. Төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд Хууль зүйн яаманд гаргаж өгөх бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгана:

1/төрийн бус байгууллагын хяг;

2/үйл ажиллагааны тухай товч мэдээлэл;

Ужилийн орлого, зарлагыг дор дурдсан ангиллаар:
а/хандивын;

б/дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны;

в/өвлүүлсэн эд хөрөнгө.

4/700000-аас дээш төгрөгийн хандив буюу өвийн хөрөнгө өгсөн байгууллага, иргэний нэр, зүйлсийн жагсаалт;

5/удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын нэр, хаяг.

3.Төрийн бус байгууллагад өргөсөн хандивыг хэрхэн зарцуулсан тухай хандивлагчдад тайлагнах эсэхээ тэдгээртэй байгуулсан гэрээнд тусгана.

4.Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг Хууль зүйн яам болон тус байгууллага нь 10-аас доошгүй жил хадгална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

24 дүгээр зүйл. Захиргааны хариуцлага хүлээлгэх

Төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх зөрчлийн шинэ байдлыг харгалзан дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/төрийн бус байгууллагын орлогоос ногдол ашиг хувиарилах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг төлөх зэрэг зөрчил гаргасан бол гэм буруутай албан тушаалтныг 40000-60000 төгрөгөөр, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох;

2/төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, ажилтнаас тухайн байгууллагын эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулсан бол албан тушаалтны тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг нь хурааж 40000-60000 төгрөгөөр торгох;

3/төрийн бус байгууллага нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчид эд хөрөнгө, хандив өгсөн бол гэм буруутай албан тушаалтныг 50000-60000 төгрөгөөр, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох;

4/энэ хуульд заасан хугацаанд үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад гаргаж өгөөгүй бол гэм буруутай албан тушаалтныг 10000-20000 төгрөгөөр торгох.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

25 дугаар зүйл. Сангийн тухай тусгай зохицуулалт

1. Энэ хуульд Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан чиг үүрэг бүхий сан хамаарах бөгөөд сан нь зөвхөн дор дурдсан зориулалтаар бусад мөнгө хандивлаж болно:

1/төрийн бус байгууллагаас нийгмийн тусын тулд явуулж байгаа ажлыг дэмжих;

2/сангийн зорилгод нийцсэн төслийг төрийн байгууллагаас хэрэгжүүлэх;

3/сангийн зорилгод нийцсэн бол хувь хүний сургалтын төлбөр болон түүнтэй холбогдох бусад зардал, хувь хүнээс явуулж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг санхүүжүүлэх;

4/иргэдийн нийгэмд тусгай үйл ажиллагааг урамшуулах.

2. Сан нь жил бүр олсон ашигжихаа 50-иас доошгүй хувийг дүрэмд заасан үйл ажиллагаандаа зарцуулна.

3. Санг татан буулгах тухай шийдвэрийг удирдах зөвлөлийн нийт гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар гаргана. Татан буугдсан сангийн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий санд шилжүүлэх бөгөөд хэрэв тийм сан байхгүй бол сангийн зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн бус байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн төрийн бус байгууллагууд нь энэхүү хуульд заасан журмын дагуу 1998 оны 1 дүгээр сарын 13-ны дотор улсын шинэчилсэн бүртгэлд бүртгүүлнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд улсын шинэчилсэн бүртгэл хийлгээгүй төрийн бус байгууллагыг Хууль зүйн яам улсын бүртгэлээс хасна.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төрийн бус байгууллага улсын шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэхэд тэдгээрийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлднө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төрийн бус байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 15, 17 дугаар зүйлийн 2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 19, 24 дүгээр зүйл, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсангаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйлийн 15 дахь заалт:

"15/агнуурын ноёд ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хуртамж;"

2/17 дугаар зүйлийн 2 дахь заалт:

"2/байгалийн ургамал ашигласны төлбөр;"

3/18 дугаар зүйлийн 2,3 дахь хэсэг:

"2. Засгийн газар нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 15-19-д заасан татварын хувь, хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан тогтооно.

3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан татварын хувь, хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан тогтооно."

4/ 19 дүгээр зүйл:

"19 дүгээр зүйл. Үндэсний татварын албаны тогтолцоо

Үндэсний татварын алба нь Үндэсний татварын ерөнхий газар, нийслэл, аймаг, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын улсын байцаагчаас бүрдэнэ."

5/ 21 дүгээр зүйл:

"21 дүгээр зүйл.Үндэсний татварын албаны удирдлага

1.Үндэсний татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна

2.Үндэсний татварын ерөнхий газар Сангийн сайдын, нийслэл, аймгийн татварын газар, хэлтэс Үндэсний татварын ерөнхий газрын, дүүргийн татварын хэлтэс, сумын татварын улсын байцаагч

нийслэл, аймгийн татварын газар, хэлтсийн удирдлага дор тус тус ажиллана.

3. Үндэсний татварын ерөнхий газар бүх шатны татварын албаны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

4. Үндэсний татварын ерөнхий газрын дарга нь нийслэл, аймгийн татварын газар, хэлтсийн даргыг, нийслэлийн татварын газрын дарга нь дүүргийн татварын хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилно.

5. Татварын улсын байцаагчийг түүний шууд харъяалдаг татварын албаны дарга томилно."

6/24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"2/анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлөгүүгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй татвар төлөгчид хуульд заасан жишгээр татвар ногдуулах;"

7/28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Татварын улсын байцаагч дүрэмт хувцас үнэ төлбөргүй хэрэглэнэ. Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална."

2 дугаар зүйл. Татварын ерөнхий хуульд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10-ын "е" дэд заалт тус тус нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлдхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна."

2/24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10-ын "е" дэд заалт:

"е) татварын өр төлбөрийг барагдуулах;"

3 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь заалтын "хүн" гэсний дараа ", Монгол Улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд" гэж; мөн зүйлийн 3 дахь заалтын "байгууллага" гэсний дараа ", сан" гэж; 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Татвар ногдуулах, суутган авах, төсөвт төлөх тооцоо хийсэн этгээдэд төлбөр тооцооны ажил, үйлчилгээний хэлс, шимтгэл олгохгүй" гэж; 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын агийн "зогсоох", б,в,г-ийн "хураах" гэсний өмнө "бүрмөсөн" гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн тогтоосон журмын дагуу" гэснийг; 16 дугаар зүйлийн 11 дэх заалт, 17 дугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн нэр, мөн хуулийн хоёрдугаар бүлгийн нэр, мөн бүлгийн 15 дугаар зүйлийн нэрээс бусад Татварын ерөнхий хуулийн "Монгол Улсын татварын" гэснийг " Монгол Улсын үндэсний татварын" гэж, "улсын татварын" гэснийг "үндэсний татварын" гэж, "татварын байцаагч" гэснийг "татварын улсын байцаагч" гэж; 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "0,3" гэснийг "0,5" гэж, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10-ын "е" гэснийг "ж" гэж; 27 дугаар зүйлийн "байж болно" гэснийг "байна" гэж тус тус өөрчилсүгэй.

6 дугаар зүйл. 1.Энэ хуулийг 1997 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2.Энэ хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг 1997 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ЭРҮҮД МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний эрүүд мэндийн даатгалын хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 5, 6 дахь заалт, мөн зүйлд дор дурдсан агуулгатай 11 дэх хэсэг тус тус нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 5 дахь заалт:

"5/Улсын эмнэлгийн поликлиник, амбулаторийн дор дурдсан шинжилгээ, үйлчилгээ:

а/иргэдийн өөрсдийн хүсэлтээр хийх бүх төрлийн лабораторийн шинжилгээ, үйлчилгээ;

б/эрүүд мэндийн дүгнэлт гаргахад шаардагдах шинжилгээ, үйлчилгээ;

в/бүх төрлийн нөхөн сэргээх үйлчилгээ;

г/биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйлчилгээ;

д/аялал жуулчлал, хувийн болон албан ажлаар гадаадад явагчдад хийх урьдчилан сэргийлэх тарилга;

е/яаралтай, амь насанд аюултай тохиолдлоос бусад үед хийх компьютер томографийн болон дүрс оношлогоо, уяг дуран, судасны зураг авах шинжилгээ.”

2/12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6 дахь заалт:

“6/Улаанбаатар хот болон аймгийн төв болох хотын дор дурдсан эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ:

а/иргэний хүсэлтээр хэвтрийн өвчтөнийг онгоц, галт тэрэгний буудал, ар гэрт нь хүргэх;

б/шарил зөөвөрлөх;

в/иргэн өөрийн хүсэлтээр эмч дуудаж зөвлөгөө авах;

г/амь насанд аюулгүй, гэрийн нөхцөлд үзүүлж болох эмчийн тусламж, үйлчилгээ.”

3/12 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

“11.Энэ зүйлийн 6 дахь хэсгийн 5, 6 дахь заалтад заасан шинжилгээ, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

2 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 2 дугаар зүйлийн “... Үндсэн хууль” гэсний дараа “...Нийгмийн даатгалын тухай хууль”, 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “...зардлыг” гэсний дараа “...эрх бүхий байгууллагатай хамтран”, 8 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “...ажлыг” гэсний дараа “...гэрээний үндсэн дээр”, 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “...сум” гэсний дараа “...баг”, мөн зүйлийн 6 дахь хэсгийн 3-ын “...нэгмэлт” гэсний дараа “эмчилгээ,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1:

“1/улсын эмнэлгийн поликлиник, амбулатори өрх /хэсэг, сум, баг/-ийн эмчийн үзлэг болон энэ хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 5-д зааснаас бусад шинжилгээ, үйлчилгээ;”

б/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2:

“2/энэ хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6-д зааснаас бусад эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ.”

в/5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Эрүүл мэндийн даатгалын орон тооны бус салбар зөвлөл /шаашид “даатгалын зөвлөл” гэх/-ийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуудна.”

г/6 дугаар зүйл:

“6 дугаар зүйл. Даатгалыг эрхлэх байгууллага

Иргэний эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалыг нийгмийн даатгалын байгууллага /цаашид "даатгагч" гэх/ эрхэлнэ. Сайн дурын даатгалыг нийгмийн даатгалын байгууллага эрхэлж болно."

д/9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Даатгалын санг даатгуулагчийн эмчилгээ, үйлчилгээ /цаашид "эмчилгээ" гэх/-ний болон даатгалын байгууллагын даатгалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна."

е/12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Даатгуулагчийн эмчилгээний зардлын төлбөрийн 90 хувийг улсын, 90 хүртэл хувийг хувийн эмнэлгийн байгууллагаас бүрдүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг үндэслэн даатгалын сангаас төлөх бөгөөд нормативг зардлын үлдэх хэсгийг энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-д заасан даатгуулагч өөрөө хариуцна. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 5, 6, 7, 8-д заасан даатгуулагчийн эмчилгээний зардлыг даатгалын сангаас бүрэн төлнө."

4 дүгээр зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4-ийн "...хөдөлмөр, эрүүл мэндийн" гэснийг "...эрүүл мэнд, нийгмийн хамгааллын", 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 5 дахь заалтын дугаарыг "7" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн "Орон сууц хувьчлах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 2

Улаанбаатар
хот

Хуулиудын төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль" батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай", "Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай", "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай", "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай" хуулиудын төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж хууль санаачлагчид буцаасугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 3

Улаанбаатар
хот

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М. Энхсайхан/-т даалгасугай:

1/ энэ хуульд заасан дүрэм, журмыг энэ оны 1 дүгээр улиралд багтаан батлах;

2/ Тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг энэ оны 2 дугаар сард багтаан өргөн мэдүүлэх;

3/ Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагыг байгуулж, бүртгэл явуулах бэлтгэл ажлыг хангуулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн байнгын хороо /С. Батчулуун/-нд даалгасугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 4

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болсонд
тооцох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын "Тэтгэвэр бодох дундаж хөдөлмөрийн хөлсний тухай" 1994 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 85 дугаар тогтоолыг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар
хот

Хүн амын нийгмийн хамгааллын талар
явах зарим арга хэмжээний
тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газар /М. Энхсайхан/-т даалгасугай:

1/1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэвэр авах нөхцөл, болзлыг хангасан иргэдийн өдөө авч байгаа тэтгэвэр,

нөхвөрийн нийлбэрийг 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 30 хувтар нэмэгдүүлж, 1997 оны 1 дүгээр улиралд багтаан олгох;

2/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д заасан иргэдэд одоо авч байгаа тэтгэвэр, нөхвөрийн хэмжээтэй тэнцэх "нөхөн олговор"-ыг тэдний өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд хөдөлмөр зохицуулалтын албадаар дамжуулан сар бүр олгох, тэдэнд дахин мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах, хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах;

3/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д заасан иргэдийн хөнгөлөлттэй тэтгэвэр болон нөхөн олговор авч байсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгуулагч шимтгэл төлбөл зохих хувиар хөдөлмөрийн баталгаат хөлснөөс тооцож тэтгэврийн даатгалын санд төрөөс хариуцан үе шаттайгаар төлөх;

4/Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүд ахуйн тухай, Хөдөлмөр эрхлэлтийн тухай, Газрын дор болон хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд ажиллагчдын салбарын даатгалын тухай, Хувиараа хөдөлмөр эрхлэгч малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах тухай хуулиудын төслийг боловсруулж 1997 оны 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/Нийгмийн халамжийн талаар төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаа, нийгмийн халамжийн санг эрхлэн зохион байгуулахдаа ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилтай нягт уялдуулан зохицуулах.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзлыг хангаагүйгээс тэтгэвэр нь зогсоогдсон иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх насандаа хүрч тэтгэвэр тогтоолгох, эсхүл нийгмийн халамжийн тэтгэвэр авах болсон тохиолдолд өндөр насны болон нийгмийн халамжийн тэтгэвэр ба нөхөн олговрын аль илүүг нь сонгон авах эрх олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 6

Улаанбаатар
хот

**Зарим элчин сайдын яамыг татан буулгах,
шинээр байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Бүгд Найрамдах Румын Улс, Бүгд Найрамдах Украин Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамыг татан буулгасугай.

2. Бүгд Найрамдах Турк Улс, Тайландын Ванг Улсад Монгол Улсын Элчин сайдын яам шинээр байгуулсугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 7

Улаанбаатар
хот

Түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох бодлого боловсруулах үүрэг бүхий Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих түр хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Түр хорооны дарга:

Л. Болд

- Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Р. Бадамдамдин

- Улсын Их Хурлын гишүүн

Бат-Эрдэнийн Батбаяр

- Улсын Их Хурлын гишүүн

Батжаргалын Батбаяр

- Улсын Их Хурлын гишүүн

Ц. Баттулга

- Улсын Их Хурлын гишүүн

Н. Баяртсайхан

- Улсын Их Хурлын гишүүн

С. Болдхэт	-Улсын Их Хурлын гишүүн
Ж. Гомбожав	-Улсын Их Хурлын гишүүн
Е. Гэрэлчулуун	-Улсын Их Хурлын гишүүн
С. Зориг	-Улсын Их Хурлын гишүүн
Р. Нарангэрэл	-Улсын Их Хурлын гишүүн
Т. Очирхүү	-Улсын Их Хурлын гишүүн
Р. Одонбаатар	-Улсын Их Хурлын гишүүн
Т. Султан	-Улсын Их Хурлын гишүүн
Р. Содхүү	-Улсын Их Хурлын гишүүн
Ц. Төмөртоогоо	-Улсын Их Хурлын гишүүн
Н. Түвшинтөгс	-Улсын Их Хурлын гишүүн
Д. Цогбадрах	-Улсын Их Хурлын гишүүн
Д. Цогт-Очир	-Улсын Их Хурлын гишүүн
М. Чимидцэрэн	-Улсын Их Хурлын гишүүн
Ц. Энхтүвшин	-Улсын Их Хурлын гишүүн
Я. Эрхэмбаяр	-Улсын Их Хурлын гишүүн

2. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох бодлого боловсруулж 1997 оны хаврын чуулганд оруулж хэлэлцүүлэхийг Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих түр хороо /Л. Болд/-нд даалгасугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар
хот

**Монголбанкинд худалдан авах алтны болон
Монголбанкнаас худалдах алт, мөнгөний
хэмжээ тогтоох тухай**

“Эрдэнэсийн сангийн тухай” Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 3; 5 дахь хэсэг болон Монголбанк, Сангийн яамны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Алт олборлох аж ахуйн нэгжүүдээс 1997 онд олборлож Монголбанкинд худалдан авах алтны доод хэмжээг 5500,0 килограмм байхаар тогтоосугай.

2. Дотоодын үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулж 1997 онд Монголбанкнаас худалдах алтны хэмжээг 193,1 килограмм, мөнгөний хэмжээг 1184,2 килограмм байхаар тус тус тогтоосугай.

3. Эрдэнэсийн гүйлгээний сана үйлдвэрүүдээс худалдан авсан алтыг тухай бүр олон улсын стандартын түвшинд зохих журмын дагуу цэвэршүүлж, үнийн тааламжтай нөхцөлд борлуулан, Улсын валютын нөөцийг нэмэгдүүлдэх арга хэмжээ авч байхыг Монголбанк /Ж. Үнэнбат/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 1 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 9.

Улаанбаатар
хот

Алт олборлолтын талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1996 онд болсон алт олборлогчдын улсын зөвлөлгөөний шийдвэр болон сүүлийн жилүүдийн алт олборлолтын ажлын үр дүнг саргалзан нарийвчлан боловсруулж байгаа "Алт-2000" төслийг 1997 оны 1 дүгээр улиралд багтаан дуусгаж, Улсын Их Хуралд ганилцуулахыг Засгийн газар /М. Энхсайхан/-г даалгасгай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 1 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 09 тоот
дүгээлтийн тухай

"Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний дийрдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" Үндсэн хуулийн цэцийн 09 тоот дүгээлтийг гэрээцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45², 50 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 09 тоот дүгнэлтийг "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-а Үндсэн хуулиар тодорхой зохицуулалтгүй орхигдуулсан харилцааг нарийвчлан зааж өгсөн нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй учир хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 10 тоот
дүгнэлтийн тухай

"Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхсайхан Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай" Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 10 тоот дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45², 50 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхий сайдын "Засаг даргын үүрэг гүйцэтгэгч томилсон тухай" 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дэх заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 10 тоот дүгнэлтийг "... аймаг, нийслэлийн Засаг даргыг томилох тухай ..." асуудлыг зохицуулсан Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт заасантай холбогдолгүй байна гэсэн үндэслэлээр уг дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Орон сууц хувьчлах, Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулиудыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Орон сууц хувьчлах тухай болон Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулиудыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь.

1/Орон сууц хувьчлах бэлтгэл ажлын хүрээнд 1997 оны 1 улиралд багтсан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-г даалгасгай:

1/Засгийн газар болон төрийн эзлэргээн төв байгууллагууд орон сууцны талбар гаргасан олоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа шийдвэрүүдийг орон сууц хувьчлахтай холбогдсон хуулиудад нийцүүлэх, хуульд заасан журам, дүрмийг батлан мөрдүүлэх;

2/орон сууцны дундын эзэмшлийн эд хөрөнгө сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд шилжихтэй холбогдон орон сууцнийгнийн аж ахуйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах;

3/орон сууцны дундын эзэмшлийн эд хөрөнгөөс сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд шилжих болон төрийн өмчлөлд үлдэх эд хөрөнгийг тогтоох, үнэлэх, шилжүүлэх аргачлал, журмыг батлан гаргах;

4/сууц өмчлөгчдийн холбоо байгуулах, дундын өмчлөлийн эд хөрөнгө холбооны мэдэлд шилжин ирэх зүүтэл зэвгээр эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, шаварлэгээ, үйлчилгээг орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудад харилцуулан гүйцэтгүүлэх;

5/сууц өмчлөгчдийн холбоог үүсгэн байгуулах, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, дундын өмчлөлийн эд хөрөнгийг сууц өмчлөгчид дундаа хамтран өмчлөхтэй холбогдсон асуудлаар сууц өмчлөгчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

6/хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн ягаан тасалбарыг үндэстэйгээр хувьчлах сууцны үнийн талборт оруулж тооцохтой холбогдуулан хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн ягаан тасалбарыг иргэд хоорондоо арилжаалах, шилжүүлэхтэй холбогдсон журмыг эрх бүхий байгууллагуудад батлуулан мөрдүүлэх;

7/аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн өмчийн орон сууцыг тухайн орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8/Орон сууцны байшин дахь сууцыг түрээсийн гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж эдгээр сууцыг хуульд заасны дагуу зориулалтаар нь ашиглах асуудлыг шийдвэртэх.

2.Орон сууц хувьчлах тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойшхи хугацаанд төрийн өмчид шилжиж ирсэн буюу шинээр ашиглалтад орсон төрийн өмчийн орон сууцыг хувьчлахдаа орон сууцны талаар явуулах төрийн нэгдсэн бодлоготой уялдуулан хуульд заасан хувьчлах арга хэлбэрүүдийг сонгон шийдвэртэж байхыг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороо /Д.Ганболд/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 1996 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 53 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Зарим гишүүдийг Байнгын хорооны
бүрэлдэхүүнээс чөлөөлөх, шинээр
батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гишүүдийн өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс Чимэдийн Сайханбилэг, Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс Батжаргалын Батбаярыг тус тус чөлөөлсүгэй.

2.Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээр Чимэдийн Сайханбилэгийг баталсугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар
хот

Журам батлах, зарим зардлын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Улсын Их Хурлын гишүүний онцгой алба гүйцэтгэсний нэмэлгдийн хэмжээг сар бүр 20000 төгрөгөөр тогтоосугай.

3. Улсын Их Хурлын гишүүн парламентын албан ёсны айлчлалаар гадаадад явахад 10000 төгрөг, танилцах аялал зэрэг бусад албан ажлаар явахад 7000 төгрөгөөр бодож жилдээ бэлэг дурсгалын зүйл явахад зориулан 17000 төгрөг, гадаадын зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зүйл өгөхөд 6000 төгрөгийн буюу улиралд 24000 хургал төгрөгийг тус тус олгож байхаар тогтоосугай.

4. Улсын Их Хурлын гишүүний эхнэр, нөхөр, төрсөн эцэг, эх, үр сүүхэд, ах, эгч, дүү нь болон өөрийн шууд асрамжид байдаг хадам нэг, ахад гачиндал тохиолдсон нөхцөлд тэдэнд 30000 төгрөгийн нэг слагийн буцалтгүй туслэмж олгож байхаар тогтоосугай.

5. Энэ тогтоолоор баталсан журмын дагуу Улсын Их Хурлын гишүүний төсвийг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах ажлыг юушион байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ 1994 ажиллахыг Тамгын газар /Д. ЦОГ/-т үүрэг болгосугай.

6. Уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн Байгуулалтын байнгын хороо /С. ЗОРИГ/, Төсвийн зарлагын яамалтын дэд хороо /А. БАЗАРХҮҮ/-нд тус тус дэлгэсугай.

7. Энэ тогтоолыг 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн өгөж мөрдсүгэй.

8. Энэ тогтоол гарсантай хөлбогдуулан "Журам батлах тухай" Улсын Их Хурлын 1994 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр тогтоол, "Улсын Их Хурлын гишүүний нэмэлд бий болгох тухай" Улсын Их Хурлын 1994 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 80 дугаар тогтоол, "Бэлэг дурсгалын зүйлийн хэмжээ тогтоох тухай" Улсын Их Хурлын даргын 1994 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 18 дугаар захирамж, "Улсын Их Хурлын гишүүн гадаадын зочин, төлөөлөгч хүлээн авч зоог барих журмын тухай" Улсын Их Хурлын

даргын 1994 оны 6 дугаар сарын 24-ний 39 дүгээр захирамж, "Төсөвт зардлын хэмжээ тогтоох тухай" Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 1994 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 50 дугаар захирамж, "Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай" Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 1994 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 112 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

Улсын Их Хурлын 1997 оны
15 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТӨСӨВТ ЗАРДЛЫГ
ТӨЛӨВЛӨХ, ТООЦОХ, ЗАРЦУУЛАХ,
ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт злассны дагуу өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсөвтэй байна.

2. Улсын Их Хурлын гишүүн /цаашид "гишүүн" гэх/-ий төсөвт зардал нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдож гишүүн бүрт төсөвлөгдөх зардал буюу өөрийн төсөв болон нийтлэг арга хэмжээний зардал гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

3. Гишүүний өөрийн төсөв нь дор дурдсан бүрэлдэхүүнтэй байна:

1/гишүүний үндсэн цалин;

2/онцгой алба гүйцэтгэсний нэмэгдэл;

3/гишүүн сонгогдсон тойрогтоо ажиллах томилолтын зардал;

4/утас, холбооны зардал /албан өрөөний болон гэрийн утсанд зөвшөөрөгдсөн пароль буюу кодоор хөт хооронд ярих/;

5/хотын дотор албаны унаа хэрэглэх зардал;

6/хэвлэл захиалгын зардлын хөнгөлөлт;

7/холбогдох шийдвэрийн дагуу олгох бусад зардал.

4. Гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг арга хэмжээний зардалд дараахь зүйл ангийн зардал орно:

1/гишүүдийн нийгэмийн даатгалын шимтгэл;

2/Улсын Их Хурлын шугамаар орон нутагт ажиллах албан томилолтын зардал;

3/гишүүдийн албан хэрэгцээний утасны хураамж болон өдөр тутмын ярилны төлбөр;

4/бичиг хэрэг, холбоо, шуудангийн зардал;

5/гишүүний туслалын зардал;

6/гишүүний сонгогдсон тойрогт нь ажиллах бие төлөөлөгчийн зардал;

7/холбогдох шийдвэрийн дагуу олгох бусад зардал.

5. Гишүүн нь төсөвт зардалаа өөрөө мэдэж зарцуулахдаа холбогдох санхүүгийн баримт, тайланг тухай бүр үнэн зөв бүтээж Тамгын газрын санхүүд өгч байна.

6. Гишүүний төсвийн гүйцэтгэлийг тэдний бүрдүүлж өгсөн санхүүгийн баримтад тулгуурлан сар бүр Тамгын газрын санхүү тооцон гаргаж Төрийн байгуулалтын байнгын хороонд болон гишүүн бүрт танилцуулж байна.

ХОЁР. Гишүүний зардлыг таловлах, төсөх

7. Гишүүний төсөвт зардалын хэмжээг мөрдөж буй жишиг, үнэ тарифыг баримтлан зардалын зүйл, анги тус бүрээр тооцон таловлаж Удсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгана.

8. Гишүүний өөрийнх нь төсөвт зардлыг энэхүү журмын 3-т тусган зардалын зүйл анги тус бүрээр дор дурасан зарчмаар тооцон таловлоно:

1/гишүүний үндсэн цалин, нэмэгдлийг мөрдөж буй шийдвэрийн дагуу;

2/гишүүний сонгогдсон тойрогтоо ажиллах томилолтын зардлыг гишүүн бүр жилд хоёр удаа, нэг удаад 20 хүртэл хоногийн хугацаатой ажиллахаар бодож тооцно.

Сонгогдсон тойрогтоо ажиллах томилолтын зардалд ор хөнгөний зардал, уг тойргийн хол ойр байршлыг хэргэлсэн нэг удаад 100-3000 хүртэл км явах унааны хөлс, тухайн аймаг, орон нутагт очиж, ирэх зардлыг тооцон таловлоно;

3/утас, холбооны зардлыг гишүүн бүрээр албан өрөөнийх нь зөвшөөрөгдсөн пароль буюу кодоор 7 хоногт дунджаар 8 минут ярихаар бодож тухайн үеийн үнэ тарифыг үндэслэн тооцно;

4/гишүүн бүр бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулж ажлын өдөрт дунджаар 30 км-ээр тооцсон жишгийн дагуу албаны унал хэрэглэнэ. Хэрэв гишүүн хүсвэл уг лимитийн 60 хувьтай тэнцэх км-т ногдох зардлыг өөрсдийнх нь мэдэлд мөнгөөр нь сар бүр олгоно;

5/гишүүнд зайлшгүй шаардлагатай төрийн төв хэвлэл захиалаард нь хөнгөлөлт үзүүлэх зорилгоор жилд нэг удаа 40000 төгрөгөөр тооцож хэвлэлийн зардал олгоно;

6/гишүүний туслал болон бие-төлөөлөгчийн цалинг мөрдөгдөж буй шийдвэрийг үндэслэн тооцож таловлоно. Бие-төлөөлөгчийн

хувьд дундаж норм баримтлан бичиг хэрэг, тойрогтоо ажиллаж томилолтын зардлыг төлөвлөж олгоно;

7/бусад зардлыг мөрдөж буй жишиг, урьд онуудын дундаж гүйцэтгэлийг харгалзан төлөвлөх бөгөөд уг зардалд гишүүний бэлэг дурсгал, зоог барих зардал зэргийг оруулан тооцно.

9. Энэхүү журмын 4-т дурдсан нийтлэг арга хэмжээнүүдтэй холбогдсон зардлыг мөрдөж буй жишиг, урьд жилүүдийн дундаж гүйцэтгэл зэргийг харгалзан Тамгын газар төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулна.

ГУРАВ. Гишүүний төсвийг зарцуулах, тайлагнах

10. Тамгын газрын санхүү нь гишүүний төсвийг гишүүн нэг бүрийн нэрээр төсөвлөн зориулалтын зүйл, ангилал зарцуулалтын явцыг байнга тооцож тайланг нэгтгэж гаргана.

11. Гишүүний төсөвт зардлыг сарлар хуваарилан тэдний хүсэлтээр сар бүрийн 10-нд тухайн сарын зардлыг санхүүжүүлэх эрхийг санхүүгээс нээж өгнө. Харин урьд сарын санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг Тамгын газрын санхүүтэй хамтран бүрэн гаргасны дараа, дараа сарын санхүүжилтийг олгодог байна.

12. Гишүүний туслахын зардлыг Тамгын газраас шууд, харин гишүүний бие-төлөөлөгчийн зардлыг орон нутгийн холбогдох Засаг даргын Тамгын газраар нь дамжуулан санхүүжүүлнэ.

13. Гишүүн нь өөрийн төсвийн зарцуулалтын санхүүгийн баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тайланг тухай бүр гаргаж байх үүрэгтэй.

14. Гишүүний төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг харгалзан улирал тутам хэтрэлт, хэмнэлтийг зардлын зүйл анги тус бүрээр гаргана.

15. Төсөвт зардалаа хэтрүүлэн зарцуулсан нөхцөлд тухайн гишүүнээр илүү зарцуулсан зардлыг бүрэн төлүүлдэг байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 2 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

**Хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх
асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 1997 оны хаврын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай:

I. Нийгмийн хамгааллын асуудалтай холбоотой хуулиуд:

1. Газрын дор болон хөдөлмөрийн хүнд, хэргэйд, халуун нөхцөлд ажиллагчдын салбарын даатгалын тухай

2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай

3. Амьжиргааны баталгаажих доод түвшингийн тухай

II. Татварын хуулиуд:

4. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

5. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

6. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай

III. Газрын тухай хуулиуд:

7. Иргэний хувийн өмчийн газрын тухай

8. Газар хувьчлах тухай

IV. Монгол Улсын Үндсэн хуульд хуулиар тусгайлан зохицуулахаар таасан хуулиуд:

9. Дайн бүхий байдлын тухай

10. Гадаадын цэргийн хүнийг байрлуулах, дамжуулан өнгөрүүлэх тухай

11. Яамдын эрх зүйн байдлын тухай

V. Бусад хуулиуд:

12. Улс төрийн талаар кэлмэгдэгсдийг цагаатгах тухай

13. Хоршооны тухай

14. Агентлагийн тухай

15. Орон сууцны тухай ерөнхий хууль

16. Аудитын магадлан шинжлэлийн тухай

17. Архивын тухай

18. Нотариатын тухай

19. Улсын Их Хурлын сонгуулийн тухай

20. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

21. Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр

22. Хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай

23. Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

24. Монгол Улсын Үндсэн хуулийн цэнгэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай

25. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн тухай

26. Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

27. Гэр бүлийн тухай

28. Бусад асуудал.

2. Улсын Их Хурлын 1997 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн Засгийн газраас өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг 1997 оны 3 дугаар сард багтаан өргөн мэдүүлдэхийг Засгийн газар /М.ЭНХСАЙХАН/-г даалгасугай.

3. Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг сайтар хангахыг Байнгын хороодын дарга нарт даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

**Хуулийг хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай**

Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-г даалгасугай:

1/Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэвтэл, мэдээллийн хэрэгслээр өргөн тайлбарлан таниулах, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг 1997 оны 3 дугаар сард багтаан хангах;

2/Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан даатгалтай иргэдэд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, тэднээс хууль бусаар төлбөр авах, чирэгдүүлэх аливаа дутагдлыг таслан зогсоох, эмчилгээ, үйлчилгээг сайжруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг салбарын дотоод бүтэц, ажлын ачаалал, зохион байгуулалтыг сайжруулах замаар гаргаж шийдвэрлэх.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

**Хуулийг хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай**

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:
Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасутай:

1/татвараас хөнгөлөх, чөлөөлөх, татвар төлүүлэх тухай бусад хуулийн заалтыг Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтад нийцүүлэх арга хэмжээ авч, холбогдох хуулийн төслийг 1997 оны 4 дүгээр сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Үндэсний татварын албыг бэхжүүлэх, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 1 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

**Япон улсын харим иргэнийг одон,
медалиар шагнах тухай**

Монгол, Японы харилцааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Япон улсын иргэн дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнастай.

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР

- | | |
|-----------------|--|
| 1. Санго Сато | -Япон улсын Парламентын зөвлө-
хүүдийн танхимын гишүүн асан |
| 2. Шингэо Озава | -Монголын эрдэмтэн |

“НАЙРАМДАЛ” МЕДАЛИАР

- | | |
|-----------------------|---|
| 1. Мүнэо Цүзүкү | -Япон, Монголын нийгэмлэгийн
тэргүүлэгч гишүүн |
| 2. Кисабүро Саканияма | -Япон Улсын Гадаад хэргийн
ламны ажилтан асан |
| 3. Такэо Ошима | -Японы сумо бөхийн дасгалжуулагч |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 1 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

**О. Отгөвсүрэнд Монгол Улсын
гавьяат багш нол олгох тухай**

Шинэжлэх ухаан, боловсролын байгууллагад он удаан жил, үүнээс Улсын багшийн дээд сургуулийн ректороор 16 жил үр бүтээлтэй ажиллаж тус сургуулийг материаллаг бааз, багшлах боловсон хүчинээр бэхжүүлэх, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй

болгож сургалт хүмүүжлийн ажлын чанарыг дээшлүүлэн улс орондоо мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгад дорвитой хувь нэмрийг нь үнэлж Улсын багшийн их сургуулийн физиклийн багш Оролжавын Отгонсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1997 оны 1 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Ч. Авдайд Монгол Улсын гавьяат
багш цол олгох тухай

Монгол улсад инженер техникийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх системийг бий болгож хөгжүүлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр ангах, технологийн салбарт судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах, арваад жилийг үйлдвэр барьж байгуулах үйлсэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Техникийн их сургуулийн тэнхимийн эрхлэгч Чинхаажавын Авдайд Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1997 оны 1 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Д. Ганчимэгт Монгол Улсын гавьяат
багш цол олгох тухай

Ерөнхий боловсролын сургуульд бага ангийн багшаар олон жил эр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин юсадтай хамтран бага ангийн сурах бичиг зохиож, бага ангийн ургалтын өөрийн өвөрмөц арга бий болгож хэрэгжүүлэн шавь

нартаа суурь мэдлэгийг даацтай олгож байгаа өндөр амжилтыг нь үнэлж Булган аймгийн Булган сумын 10 жилийн 1 дүнд сургуулийн бага ангийн багш Даваасүрэнгийн Ганчимэгт Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 1 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Зарим багш, ажилтныг одон,
медальнар шагнах тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, өсвөр үеийнхний авьяас чадварыг хөгжүүлэх, зохих шатны боловсрол эзэмшихэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан их, дээд сургууль-колледж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, сургагч хүмүүжүүлэгч, ажилтнуудыг одон, медальнар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР

1. Дашийн Содномгомбо
МУИС-ийн нийгмийн
ухааны тэнхимийн багш

Их, дээд сургуульд нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, багшаар 30 гаруй жил ажиллаж сүүлийн жилүүдэд улс төр судлалын тэнхим байгуулах санаачилга гарган хэрэгжүүлж, улс төр судлал, нийгмийн болон түүхийн гэрээ ухаан зэрэг 4 шинэ хичээлийг эвэж "Ардчилал, мөн чанар, түүхэн хэлбэрүүд" зэрэг олон ном өгүүлд бичиж нийгмийн шинжлэх ухааны шинэчлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

2. Жаргалын Лхамсүрэн
Техникийн их сургуулийн геологи, уул уурхайн сургуулийн багш

Боловсрол, шинжлэх ухааны байгууллагад 40 шахам жил ажиллаж геолог материалогийн тэнхим, музейг үүсгэн байгуулах ажилд голлон оролцож оло

арван мэргэжилтэн боловсон хүчин, эрдэмтдийг бэлтгэх, геологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг өргөтгөхөд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

3. Дондогийн Дагвадорж
УБИС-ийн нийгмийн
ухааны тэнхмийн
эрхлэгч

Их, дээд сургуульд нийгмийн ухааны багш, тэнхмийн эрхлэгчээр 30 гаруй жил ажиллаж олон мэргэжилтэн бэлтгэхийн зэрэгцээ "Гүн ухааны товчоо", "Бурхны шашин" зэрэг олон бүтээл туурвиж сүүлийн жилүүдэд дорно дахины гүн ухаан тогтсон тааллын онол, суртахууны үндсийг боловсруулан анх удаа сургалтын төлөвлөгөөнд оруулан заах зэргээр нийгмийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

4. Пунцагийн Рэнжин
Нийслэлийн Ажилчин
залуучуудын ээлжийн II
дунд сургуулийн захирал

Боловсролын болон хүүхдийн байгууллагад 50 шахам жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн 19 жилд ажилчин залуучуудын ерөнхий боловсролын сургуулийг чадварлаг зохион байгуулан удирдаж, 10 гаруй мянган хүнд бүрэн ба бүрэн бус дунд боловсрол эзэмшүүлэн, олон хүний их, дээд сургууль, коллежид элсэн суралцах нөхцөлийг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УДААН ТУГИЙН ОДОНГООР

- Гомбосүрэнгийн
Батмөнх
АУИС-ийн физиоло-
гийн тэнхмийн багш

Боловсролын салбарт сургалт эрдэм шинжилгээ, хүмүүжлийн ажлыг хослуулан 36 жил үр бүтээлтэй ажиллан их, дээд сургуулийн "Шавь" төвтэй сургалтыг бүтээлчээр хэрэгжүүлж хичээлийн нэгдсэн аргачлал зохиож тэнхмийн сургалтад нэвтрүүлэх, багш оюутнуудад зориулж хэд хэдэн сурах бичиг, гарын авлага, эрдэм

шинжилгээний бүтээл туурвиж, дээд боловсролтой олон мянган мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

2. Пунцагийн Санжид ХААИС-ийн ХАА-н эдийн засгийн хүрээлэнгийн дэд захирал

Олон жил дээд сургуулийн ректороор ажиллаж сургалтыг боловсронгуй болгох, үйлдвэрлэлтэй холбох, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, чанарын удирдлагын иж бүрэн системийг өөрөө боловсруулан нэвтрүүлж, дээд сургуулийн хэд хэдэн сурах бичиг, эрдэм шинжилгээний бусад олон бүтээл туурвисныг нь үнэлж

3. Лувсандэлгын Бат-Очир МУИС-ийн нийгмийн судалгааны төвийн эрхлэгч

Их, дээд сургуулийн нийгмийн ухааны багшаар олон жил ажиллаж хичээлийн хэрэгцээгээхүүн, гарын авлагаар хангаж олон мянган мэргэжилтэн, зэрэг цолтой эрдэмтэд бэлтгэхэд оруулсан хувь нэмэр болон эрдэм шинжилгээний олон бүтээл туурвиж, нийгмийн шинжлэх ухааныг шинэчлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

4. Цэрэндуламын Раднаа Соёл урлагийн их сургуулийн бүжгийн тэнхмийн багш

Боловсролын болон төв, хөдөөгийн урлагийн байгууллагад 50 шахам жил ажиллаж олон үеийн хэдэн арван мэргэжлийн уран бүтээлчдийг бэлтгэхийн зэрэгцээ бүжиг, театрын урлагийг хөгжүүлэх, тэдгээрийн урын санг баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

5. Лэгцэгийн Өвгөн МУИС-ийн Математикийн факультетийн багш

Дээд боловсролын системд тасралтгүй 37 жил ажиллахаар их, дээд сургуулиудын сургалтын агуулга, хэлбэрийг боловсронгуй болгох, математик физикийн багш бэлтгэх, шинжлэх ухааны тодорхой салбараар шавь сургууль үүсгэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

6. Лайхансүрэнгийн
Лхасүрэн
Соёл урлагийн их
сургуулийн ахлах багш
- Боловсролын болон урлагийн байгуулла-
лагад олон жил үр бүтээлтэй ажиллаж
мэргэжлийн боловсон хүчин бэлтгэ-
хийн зэрэгцээ үзэгчдийн талархал
хүлээсэн "Бола хэрхэн хатаагдсан нь"
жүжгийн Павел Корчагин, "Гарын
таван хуруу" киноны Шагдар зэрэг 100
гаруй гол, туслах дүрийг чадварлаг
бүтээж, олон жүжиг, концертыг мэр-
гэжлийн өндөр түвшинд найруулах
зэргээр монголын соёл урлагийг
хөгжүүлэхэд оруулж байгаа байгаа хувь
нэмрийг нь үнэлж
7. Шагжийн Цэвэлмээ
Улаанбаатар хот дахь
Багшийн коллежийн
багш
- Тус сургуульд 38 жил тасралтгүй
багшилж өсвөр залуу үеийг сурган
хүмүүжүүлэх үйлсг бүтээлч санаачилга
гарган олон мянган мэргэжлийн
боловсон хүчин бэлтгэхэд оруулсан
хувь нэмэр болон шинэ бүтээл
оновчтой санал гаргаж бичиг ангийн
сургалтыг боловсронгуй болгож байгаа
амжилтыг нь үнэлж
8. Нямын Бавуужав
Баянхонгор аймгийн
Баянхонгор сумын 10
жилийн II сургуулийн
зураг, шугам зургийн
багш
- Сурагчдын гоо зүй-урлагийн сэтгэлтээ,
авьяасыг хөгжүүлэхэд онцгой анхаарч,
заадаг хичээлийн амжилт, чанарыг
дээшлүүлэн, сонгон суралцах хичээл-
ийг амжилттай явуулж 20 шөхөм
хүүхэд багшийнхаа мэргэжлийг өвлөн
эзэмшихэд оруулсан хувь нэмэр болон
олон ном сурах бичгийн зураг
чимэглэлийг хийж дүрслэх урлагийн
олон бүтээл туурвисныг нь үнэлж
9. Жамцын Балсанжав
Орхон аймгийн 10
жилийн I сургуулийн
биологийн багш
- Заах аргын өндөр ур чадвар эзэмшин
тайланг, үзүүлэх, нээлттэй хичээл
байнга явуулж, сургалтын шинэ аргуу-
дыг оновчтой хослон хэрэглэснээр
сурагчдын авьяас чадварыг нээн ил-
рүүлдэг бие даасан үйл ажиллагааг нь
хөгжүүлж, шавь нар нь биологийн
улсын олимпиадад тогтмол эхний

байрууд эзлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

10. Дүгэрийн Рэнчин
Хэнтий аймгийн
Хэрлэн сумын 10
жилийн 1 сургуу-
лийн захирал

Тус сургуулийн хамт олныг сайнзохион байгуулан удирдаж багш ажилчдын идэвх санаачилгыг өрнүүлэх, анги танхимыг тохижуулах, сурлага, хүмүүжлийн чанарыг дээшлүүлэх талаар гарч байгаа амжилт болон биеийн тамирын багшаар ажилласан хугацаанд олон зуун зэрэгтэй тамирчид бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

11. Долгорын Цэдэв
Сэлэнгэ аймгийн
Боловсролын төвийн
захирал

Тус аймгийн сургууль, цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэх, багшлах боловсон хүчинээр хангах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэргээр боловсролын байгууллагыг хөгжүүлэх, өөрчлөн шинэчлэх, өсвөр залуу үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

- | | |
|-------------------------------|---|
| 1. Гомбожавын
Даваасамбуу | Гадаад хэлний дээд сургуулийн тэнх-
мийн эрхлэгч |
| 2. Тарпаны Нигамет | Хөдөө аж ахуйн их сургуулийн трактор
автомашин тэнхмийн багш |
| 3. Довчингийн Отгонсүрэн | Улсын багшийн их сургуулийн монгол
хэлний тэнхмийн багш |
| 4. Намсрайжавын
Алтангэрэл | Мөн сургуулийн ерөнхий ба тур-
шилтын физикийн тэнхмийн багш |
| 5. Баасангийн
Шаравнямбуу | МУИС-ийн Хууль зүйн дээд сургуу-
лийн хичээлийн эрхлэгч |
| 6. Цэ-Одын Гомбосүрэн | "Цог" гадаад хэлний дээд сургуулийн |

багш

- | | |
|----------------------------|--|
| 7. Дамийн Төмөртөгөө | УБИС-ийн хэл шинжлэлийн тэнхмийн багш |
| 8. Доржийн Халтарпүрэв | Архангай аймаг дахь Багшийн коллежийн захирал |
| 9. Сунгарааны Болд | Дархан-Уул аймгийн Дархан сумын 10 жилийн III сургуулийн захирал |
| 10. Шатарын Цэсэм | Дундговь аймгийн Сайнцагаан сумын 8 жилийн сургуулийн бага ангийн багш |
| 11. Сампилын Пүрэвжав | Хөвсгөл аймгийн Галт сумын 10 жилийн сургуулийн захирал |
| 12. Шунуугийн Чулуунбор | Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 10 жилийн II сургуулийн хичээлийн эрхлэгч |
| 13. Дагвын Долгоржав | Нийслэлийн Багануур дүүргийн 10 жилийн 66 дугаар сургуулийн математикийн багш |
| 14. Рамазаны Алданыш | Нийслэлийн Баянгол дүүргийн 22 дугаар сургуулийн Биеийн тамирын багш |
| 15. Загдхүүгийн Баянжаргал | Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 36 дугаар сургуулийн бага ангийн багш |
| 16. Дагвын Жагшив | Мөн дүүргийн 10 жилийн 81 дүгээр сургуулийн захирал |
| 17. Дамдингийн Мижиддорж | Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 31 дүгээр сургуулийн түүхийн багш |
| 18. Очирын Оюунцэцэг | Хөнгөн үйлдвэрийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дэд захирал |

- | | |
|----------------------------------|---|
| 19. Раднаасэдийн
Санжаасүрэн | Гэгээрлийн яамны Шинжлэх ухаан,
технологийн газрын дарга |
| 20. Банзайн Дамдинсүрэн | Мөн яамны ахлах мэргэжилтэн |
| 21. Дамбадаржаагийн
Буудайхүү | Мөн яамны мэргэжилтэн |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

- | | |
|----------------------------------|---|
| 1. Намжилын Цэен | МУИС-ийн Хууль зүйн дээд
сургуулийн багш |
| 2. Сэнгээгийн
Пунсалдулам | Архангай аймгийн Хангай сумын 8
жилийн сургуулийн бага ангийн багш |
| 3. Телеубайн Тохтархан | Баян-Өлгий аймгийн Толбо сумын 10
жилийн сургуулийн захирал асан |
| 4. Рэнжээгийн Маналжав | Булган аймгийн Хишиг-Өндөр сумын
10 жилийн сургуулийн хичээлийн
эрхлэгч |
| 5. Мижидийн Нямжав | Говь-Алтай аймгийн Жаргалан сумын
8 жилийн сургуулийн хөдөлмөрийн
багш |
| 6. Дашдэндэвийн
Амгалансайхан | Дорнод аймгийн Хэрлэн сумын 10
жилийн 5 дугаар сургуулийн хичээ-
лийн эрхлэгч |
| 7. Риймаагийн
Эрдэнэцэцэг | Мөн аймаг дахь Багшийн коллежийн
монгол хэлний багш |
| 8. Рэнцэнгийн Жавзан | Завхан аймгийн Улиастай сумын 1
дүгээр цэцэрлэгийн эрхлэгч |
| 9. Замбалын Пүрэвнэмэд | Мөн аймгийн Улиастай сумын 10
жилийн 2 дугаар сургуулийн захирал |
| 10. Цэдэнгийн Дэжидмаа | Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын
10 жилийн 1 дүгээр сургуулийн монгол
хэл, уран зохиолын багш |

- | | |
|-------------------------------|---|
| 11. Балжинням
Агьяабатар | Өмнөговь аймгийн Номгон сумын 8
жилийн сургуулийн физикийн багш |
| 12. Содовын Гэлгөө | Төв аймгийн Зүүнмад сумын 1 дүгээр
цэцэрлэгийн эрхлэгч |
| 13. Лхаасүрэнгийн
Дэмбэрэл | Увс аймгийн Малчин сумын дунд
сургуулийн газар зүйн багш |
| 14. Намжилын Чулуун | Мөн аймгийн Улаангом сумын 10
жилийн 2 дугаар сургуулийн орос
хэлний багш |
| 15. Цүлтэмийн
Дангаасүрэн | Ховд аймгийн Булган сумын 10
жилийн сургуулийн биеийн тамирын
багш |
| 16. Цэрэндуламын Ламжав | Нийслэлийн Баянгал дүүргийн 10
жилийн 54 дүгээр сургуулийн бүжгийн
багш |
| 17. Таяагийн Доржготов | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 41
дүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч |
| 18. Амгалангийн
Ичинхорлоо | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 50
дугаар сургуулийн бага ангийн багш |
| 19. Дэжидийн Долгорсүрэн | Нийслэлийн 29 дүгээр тусгай сургуу-
лийн согот зүйч багш |
| 20. Содовын Пунсал | Гэгээрлийн яамны харьяа "Байгаль эх"
төвийн цэцэрлэгч |
| 21. Шаранямбуугийн
Наташа | Өсвөрийн зохион бүтээгчдийн төвийн
хөдөлмөрийн багш |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 2 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Гадаад харилцааны байгууллагын
зарим ажилтныг одон, медалиар
шагнах тухай

Гадаад харилцааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж тус улсын гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, улс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР

- | | |
|------------------------------|--|
| 1. Рагчаагийн Баасан | -ГХЯ-ны 1 дүгээр газрын мэргэжилтэн |
| 2. Дашийн Бат | -Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамны 1 дүгээр нарийн бичгийн дарга |
| 3. Лувсангийн Баттулга | -ГХЯ-ны гадаад худалдаа, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн |
| 4. Пагамжавын Бүдрэгчаа | -ГХЯ-ны 2 дугаар газрын мэргэжилтэн |
| 5. Жанцангийн Гэлгөө | -Монгол Улсаас Англи Улсад суугаа Элчин сайдын яамны худалдааны атташе |
| 6. Батжаргалын
Жамбалдорж | -ГХЯ-ны гэрээ, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| 7. Пунцагноровын
Нарангуа | -ГХЯ-ны гадаад худалдаа, хамтын ажиллагааны газрын орлогч захирал |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

- | | |
|------------------------|-------------------------------|
| 1. Хараавчийн Аюурзана | -Монгол Улсаас БНХАУ-д суугаа |
|------------------------|-------------------------------|

Элчин сайдын яамны зөвлөх

2. Гүнчингийн Батцэнгэл -ГХЯ-ны гадаад худалдаа, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн
3. Ойдовын Нямдавал -ГХЯ-ны I дүгээр газрын мэргэжилтэн
4. Цогтын Нямсүрэн -ГХЯ-ны олон улсын байгууллагын газрын мэргэжилтэн
5. Гончигсүрэнгийн Оюунчимэг -Монгол Улсаас Франц Улсад суугаа ЭСЯ-ны худалдаа, эдийн засгийн атташе
6. Жанжалгийн Хоролсүрэн -Монгол Улсаас БН Куба Улсад суугаа Элчин сайдын яамны III нарийн бичгийн дарга
7. Балбарын Цэрэндорж -ГХЯ-ны I дүгээр газрын мэргэжилтэн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 2 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот

Загарын Эрэндоод дипломат цол
олгох тухай

Монгол Улсын дипломат алба сэргэн байгуулагдсаны 75 жилийн эйг тохиолдуулан гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж Загарын Эрэндоод Монгол Улсын Онц Бөгөөд Бүрэн эрхт элчин цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 2 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хог

Зарим багш нарыг шагнах тухай

“Говийн малчин эмэгтэйчүүдийн сурах хэрэгцээг хангах албан бус боловсрол” төслийг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажилласныг нь үнэлж Өмнөговь аймгийн Сэврэй сумын явуулын багш Пандийн Маамыг Алтан гадас одонгоор, Баянхонгор аймгийн Боловсролын төвийн арга зүйч Агваанжавын Лосолмаа, мөн аймгийн Баацагаан сумын явуулын багш Галдангийн Дагиймаа нарыг Хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Хариуцлагатай нарийн бичгийн дарга	Б. Ганбат
Гишүүд:	Б. Бадамхаял Ч. Дашням Б. Цэндлоо Б. Чингид Б. Эгэлбиш
Техник редактор	С. Итгэлт
Уншигч хянасан	Сая. Жаргалсайхан Б. Явжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1997 оны 3-р сарын 4-нд
Өрөлтөд 1997 оны 3-р сарын 6-нд Хэвлэлтэд
1997 оны 3-р сарын 18-нд Хэвлэлийн хуудас 5,5
Хэвлэсэн тоо 4453

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг
Эрхлэх Газрын харьяа
Хэвлэх үйлдвэр

